



**Монгол Улсын Авлигатай тэмцэх газар**

**МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ,  
АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

## АГУУЛГА

НЭГ. МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ .....	3
1.1 АВЛИГЫН ЭСРЭГ ОЛОН НИЙТИЙГ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР .....	3
1.2 ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ, ХАДГАЛАХ, ХЯНАН ШАЛГАХ ЧИГЛЭЛЭЭР .....	10
1.3 ИРГЭД, БАЙГУУЛЛАГААС ИРСЭН ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ ХЯНАН ШАЛГАХ ЧИГЛЭЛЭЭР .....	16
1.4 ХУУЛИАР ХАРЬЯАЛУУЛСАН ГЭМТ ХЭРЭГТ ЯВУУЛСАН МӨРДӨН БАЙЦААЛТЫН ЧИГЛЭЛЭЭР .....	17
1.5 ГАДААД ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР .....	20
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ .....	22
2.1 АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС .....	22
2.2 ДЭЛХИЙН НИЙТИЙН АВЛИГЫН ХЭМЖҮҮР СУДАЛГАА .....	23
2.3 МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ИНДЕКС .....	24
2.4 ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ .....	29
2.5 УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТӨСӨӨЛӨЛ .....	30
2.6 АВЛИГЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ МЭДЛЭГ ТОГТООХ СУДАЛГАА .....	31
2.7 БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ .....	32
ГУРАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ .....	35

## **НЭГ. МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

---

Авлигатай тэмцэх газар нь Монгол Улсад шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлэн, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн өргөн оролцоотойгоор улсын хэмжээнд зохион байгуулав.

Монгол Улсын Их Хуралд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим зүйл, заалт, УИХ-ын 2007 оны 07, 2008 оны 13, 2011 оны 55, 2012 оны 55 дугаар тогтоол, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 5 дугаар тогтоолын хэрэгжилт болон авлигын ерөнхий нөхцөл байдлыг мэдээлж байна.

### **1.1 АВЛИГЫН ЭСРЭГ ОЛОН НИЙТИЙГ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**

**Төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх аргачлалын дагуу төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлгээ хийж, үр дүнг олон нийтэд зарлав.** Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д заасан “улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих” чиг үүргийн дагуу төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор “Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ыг боловсруулж, төрийн байгууллагуудад хүргүүллээ. Уг аргачлал нь төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг шинэ шатанд хүргэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд хяналт тавих боломжийг олгох, шударга ёсыг бэхжүүлэх, хариуцлагыг чангатгах, нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх, олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ төгс биелүүлэхэд чиглэсэн төдийгүй тухайн байгууллагаас хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнд нь цогц байдлаар үнэлгээ өгөх онцлог, ач холбогдолтой юм.

Дээрх аргачлалын дагуу Авлигатай тэмцэх газраас нээлттэй сонгон шалгаруулалтын үр дүнд шалгарсан хөндлөнгийн “Шинжээчдийн баг”-аар Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг болон удирдлага нь томилогддог байгууллага, яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 48 аж ахуйн нэгж, нийт 120 байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийлгэж, хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг 0-70 оноо, авлигатай тэмцэх санал, санаачилгыг 0-30 оноогоор тус тус үнэлэн үр дүнг олон нийтэд зарласан. Энэхүү үнэлгээ нь Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-д заасан үнэлгээний бүрэлдэхүүн хэсэг болж байна.

**Хүснэгт 1. Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааны үнэлгээ, хувиар**

№	Байгууллагын нэр	Авсан оноо
<b>Яам, агентлаг</b>		
1	Улсын бүртгэлийн ерөнхий газар	74.5
2	Цөмийн энергийн газар	72.5
3	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	72.5
4	Хил хамгаалах ерөнхий газар	71
5	Худалдан авах ажиллагааны газар	69.5
6	Санхүүгийн зохицуулах хороо	69
7	Хөдөлмөрийн яам	65.5
8	Төрийн өмчийн хороо	65
9	Сонгуулийн ерөнхий хороо	65
10	Татварын ерөнхий газар	64
11	Зам тээврийн яам	64
12	Үндэсний статистикийн хороо	63.5
13	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	62.5
14	Барилга, хот байгуулалтын яам	62.5
15	Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар	62
16	Хууль зүйн яам	62
17	Нийгмийн даатгалын ерөнхий газар	60.5
18	Ус, цаг уур, орчны шинжилгээний газар	60.5
19	Архивын ерөнхий газар	59.5
20	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар	58.5
21	Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар /хуучин нэрээр/	58.5
22	Сангийн яам	58
23	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	57.5
24	Мал эмнэлэг, үржлийн газар	57.5
25	Цагдаагийн ерөнхий газар	55.5
26	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	55.5
27	Ашигт малтмалын ерөнхий газар	54.5
28	Уул уурхайн яам	53.5
29	Стандартчлал, хэмжил зүйн газар	53
30	Зэвсэгт хүчний жанжин штаб	53
31	Иргэний нисэхийн ерөнхий газар	52
32	Боловсрол, шинжлэх ухааны яам	51.5
33	Эрүүл мэндийн яам	51
34	Батлан хамгаалах яам	50.5
35	Газрын харилцаа, геодези зураг зүйн газар	50.5
36	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	50.5
37	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам	50
38	Соёл, спорт, аялал, жуулчлалын яам	46.5
39	Онцгой байдлын ерөнхий газар	43.5
40	Хүний эрхийн үндэсний комисс	43
41	Эдийн засгийн хөгжлийн яам	43
42	Үндэсний аудитын газар	42.5
43	Хүүхдийн төлөө үндэсний газар	42
44	Төрийн албаны зөвлөл	39.5
45	Эрчим хүчний яам	38
46	Монгол банк	33

47	Гадаад харилцааны яам	32.5
48	Оюуны өмчийн газар	29.5
49	Гаалийн ерөнхий газар	26.5
50	Газрын тосны газар	19.5
<b>Аймаг, нийслэл</b>		
1	Орхон аймгийн ЗДТГ	82
2	Дундговь аймгийн ЗДТГ	76
3	Хэнтий аймгийн ЗДТГ	72
4	Увс аймгийн ЗДТГ	69
5	Өвөрхангай аймгийн ЗДТГ	67
6	Дорнод аймгийн ЗДТГ	67
7	Өмнөговь аймгийн ЗДТГ	66
8	Дархан-Уул аймгийн ЗДТГ	59
9	Нийслэлийн ЗДТГ	58
10	Говь-Алтай аймгийн ЗДТГ	57
11	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	57
12	Төв аймгийн ЗДТГ	56
13	Дорноговь аймгийн ЗДТГ	55
14	Булган аймгийн ЗДТГ	54
15	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	53
16	Архангай аймгийн ЗДТГ	53
17	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	45
18	Баянхонгор аймгийн ЗДТГ	41
19	Завхан аймгийн ЗДТГ	37
20	Ховд аймгийн ЗДТГ	34
21	Хөвсгөл аймгийн ЗДТГ	24
22	Сүхбаатар аймгийн ЗДТГ	2

Шинжээчдийн багаас төрийн байгууллагууд цахим хуудасныхаа агуулгыг хуульд заасан шаардлагад нийцүүлэн, бүтэц загварын хувьд иргэдэд ойлгомжтой, хэрэглэхэд хялбар, хүртээмжтэй болгох, дэд бүтцийг сайжруулах, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа хуулиар тогтоосон агуулгын шаардлагад нийцүүлэн, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан хугацаанд мэдээлэл оруулах асуудлыг хариуцах ажилтныг тодорхойлж, график тогтоон байнга мөрдөж, хэрэгжүүлсэн ажлаа тухайн үед нь нотлох баримтаар баталгаажуулж хэвших, төлөвлөгөөний тайланг Авлигатай тэмцэх газарт ирүүлэхдээ төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг нэгбүрчлэн тусгаж, тухайн ажил, арга хэмжээг хэрэгжүүлсэн нотлох баримтыг бүрэн хавсаргаж байх зэргийг зөвлөсөн байна.

**Төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, арилжааны банкинд холбогдох зөвлөмж хүргүүлж ажиллалаа.** Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах асуудлаар 100 байгууллагад, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг зөрчигдөж, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 15 байгууллагад, Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, байгууллагын үйл ажиллагаа, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах талаар 20 аймагт, нийтийн албан тушаалтанд бэлэг, санхүүгийн бусад туслалцаа үзүүлэхгүй байх хуулийн заалтыг хэрэгжүүлэх талаар арилжааны 13 банкинд,

Нийтийн албан тушаалтан орон нутагт албан томилолтоор ажиллах явцдаа орон нутгийн төсвийн нөөц сангаас зочид буудал, хоолны зардлыг төлүүлдэг асуудлыг таслан зогсоох талаар 158 байгууллагад Зөвлөмж боловсруулан тус тус хүргүүлээ.

**Хүнд суртал үүсгэсэн, хууль зөрчсөн холбогдох тогтоол, журмыг хянан үзэж, өөрчлөх, хүчингүй болгоход чиглэсэн арга хэмжээ авахуулахаар зохих газруудад хүргүүлэв.** Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.2-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”, Өмнөговь аймгийн Засаг даргын 2010 оны а/470 дугаар захирамжаар баталсан “Орон нутгийн нөөц санг төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлийг тооцох журам”, Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалаар баталсан “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” журам, Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын 2012 оны А/55 дугаар тушаалаар баталсан “Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээг тодорхойлох мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2008 оны 50 дугаар тушаалаар баталсан “Хорих ангийн дотоод журам”, Өмнөговь аймгийн Даланзадгад сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 46 дугаар тогтоолоор баталсан “Даланзадгад сумын нутаг дэвсгэрт түр шилжин суурьших иргэдийг бүртгэх, хяналт тавих журам, “Гадаадын иргэнийг бүртгэх журам” болон Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Засаг даргын 2013 оны 7 дугаар захирамжийг тус тус хянан үзэж, өөрчлөх, хүчингүй болгоход чиглэсэн арга хэмжээ авахуулахаар холбогдох газруудад хүргүүлснээр зохих үр дүн гарлаа. Тухайлбал, төрийн болон хувийн хэвшлийн сургуулиудад үндэсний тэтгэлгийг харилцах дансаар дамжуулан оюутанд шууд олгох, суралцагчийн зөвшөөрөлгүйгээр аливаа төрлийн төлбөр /сургалтын, кредитийн зөрүү, г.м/-ийн суутгалд тооцохгүй байх, тэтгэлэг олголттой холбоотой мэдээллийг ил тод, нээлттэй болгох арга хэмжээг авч ажиллах, түүнд хяналт тавих асуудлыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад уламжилснаар суралцагчийн тэтгэлгийг сургуулиар дамжуулахгүйгээр Сургалтын төрийн сангаас шууд оюутны дансанд шилжүүлдэг тогтолцоонд шилжүүлэх шийдвэр гаргуулсан.

**Хууль тогтоомж сурталчлах, олон нийтийн санал хүсэлтийг сонсох, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр арга зүйн удирдлагаар хангаж ажиллалаа.** Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлах, орон нутгийн иргэд, олон нийттэй уулзаж санал хүсэлтийг нь сонсох, төрийн болон төрийн өмчит байгууллагуудын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, арга зүйн удирдлагаар хангах зорилго бүхий ажлын хэсгийг 20 аймагт томилон ажиллуулав. Авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах, зөрчил дутагдлыг арилгахад чиглэсэн тусгайлсан арга хэмжээг авах зорилгоор Өмнөговь аймаг болон тус аймгийн 15 сум, Хөвсгөл, Булган, Баян-Өлгий аймгуудад ажиллав. Тухайлбал, Өмнөговь аймагт томилолтоор ажиллахдаа байр, зам хоногийн зардлаа тус аймгийн орон нутгийн төсвийн нөөц сангаас гаргуулсан зөрчил гаргасан 13 албан хаагчийн харъяалах байгууллагад нь хариуцлага тооцуулахаар хандсан бөгөөд үүний мөрөөр 4 албан хаагчид холбогдох арга хэмжээг авсан байна. Мөн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд гаргасан аймгийн Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалуудтай нэг бүрчлэн танилцсан бөгөөд тус аймгийн хэмжээнд удирдах албан тушаалтнуудаас хөрөнгө зарцуулахтай холбогдуулан гаргасан

шийдвэрүүдийн хөрөнгийн эх үүсвэр орон нутгийн давсан орлогоос гаргахаар байгаа нь анхаарал татаж байсан төдийгүй зарим тохиолдолд төсвийн хийдэл, төсвийн хэмнэлтээс зарцуулахаар шийдвэрлэсэн нь төсвийн хэмнэлт, хийдлийг урьдаас төлөвлөдөг мэт ойлголт төрүүлэхээр байв. Эдгээр шийдвэрүүдийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гарсан эсэхийг судлан үзсэн ба нийт орон нутгийн төсвийн орлогын давсан хэсэг, Засаг даргын нөөц сангаас 340 гаруй сая төгрөгийг зарцуулсан шийдвэрийг тусгайлан шалгуулахаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хандаад байна.

**Худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг нээлттэй, ил тод болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэв.** Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын цахим хуудсанд байршуулсан худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, зарлагдсан 479 ажлын урилга болон гэрээ хийгдсэн 250 ажлын үр дүн, шалгарсан, шалгараагүй компанийн шалтгаан зэргийг ил тод, нээлттэй болгуулав.

**Сум хөгжүүлэх сангийн зээлтэй холбоотой асуудлаар мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлж, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоход анхааран ажиллаж байна.** Орон нутагт ажиллах явцад сум хөгжүүлэх сангийн зээлтэй холбоотой гомдол мэдээлэл их гарч байсантай холбогдуулан энэхүү зээлийг зохицуулж буй Засгийн газрын журмыг илүү ил тод, нээлттэй болгох, иргэдийг зээл авах тэгш боломжоор хангах чиглэлээр Авлигатай тэмцэх газрын дарга болон Хөдөлмөрийн сайдын тушаалаар хамтарсан ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан. Уг журмыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг Хөдөлмөрийн сайдын тушаалаар байгуулагдан ажиллаж, Сум хөгжүүлэх сангийн журмын төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон бөгөөд улмаар Сум хөгжүүлэх сангийн журмыг батлах эрх зүйн үндэслэлийг холбогдох хуульд тусгах чиглэлээр Засгийн газарт санал хүргүүлэхээр тогтоод байна.

**Нийслэлийн Засаг даргын дэргэдэх холбогдох байгууллагуудтай хамтран “Хамтдаа” төслийг хэрэгжүүлэн, авлигаас урдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.** Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар, Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, Өмчийн харилцааны газарт Азийн сан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран 2013-2014 онд хэрэгжүүлэх сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх “ХАМТДАА” төслийг хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд салбарын хэмжээнд мөрдөгдөж буй дүрэм, журмын жагсаалтыг гаргах, дүрэм, журам, тушаал, шийдвэрийг хянах аргачлалын төсөл боловсруулах, сургалт зохион байгуулах, газар өмчлөл, эзэмшилтэй холбоотой мэдээллийг ил тод болгуулах, мэдээллийг цахим хэлбэрт оруулах ажлыг эхлүүлэх зэрэг шат дараалсан арга хэмжээг зохион байгуулж байна.

**Авлигын эсрэг аяны хүрээнд албан тушаалтны ёс зүйг дээшлүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажиллав.** Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Баянзүрх болон Чингэлтэй дүүрэгт нэг сарын аяныг тус тус зохион байгууллаа. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хууль сурталчлах, нийтийн албан тушаалтны ёс зүйг дээшлүүлэхтэй холбоотой ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэхэд анхаарч, удирдлага болон авлигаас урьдчилан

сэргийлэх асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтныг мэдээлэл арга зүйгээр хангах, сургалтад хамруулах замаар хамтарч ажиллав. Тухайлбал, “Нэг сарын аян”-ы хугацаанд Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын харьяа хэлтэс, Мэргэжлийн хяналт, Газрын алба, дүүргийн 28 хороод, “Усан спорт сургалтын төв” орон нутгийн өмчит хуулийн этгээд, Засаг даргын Тамгын газрын төрийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид заасан хэмжээнд ил тод, нээлттэй болгосон ба зарим хороод, орон нутгийн өмчит хуулийн этгээд, Газрын албанд илэрсэн зөрчил дутагдлуудыг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авлаа. Мөн 28 хороонд иргэдэд оршин суугчийн тодорхойлолт өгөхтэй холбоотойгоор 100 төгрөгийн хураамж авч байсныг таслан зогсоож, орон нутгийн өмчит хуулийн этгээдээс үзүүлж байгаа үйлчилгээний үнэ тарифыг үндэслэлтэй тогтоох талаар шийдвэр гаргуулахад ахиц дэвшил гаргалаа.

**Эрүүл мэндийн салбар дахь авлига, ашиг сонирхлын зөрчлийг бууруулахад онцгой анхаарч ажиллав.** Сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн салбартай холбоотой авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх гомдол, санал, хүсэлт манай байгууллагад тасралтгүй ирэх болсонтой холбогдуулан Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, нийслэлийн хоёр, гуравдугаар амаржих газрууд, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг зэрэг байгууллагуудад ажиллан, зөрчил дутагдлыг илрүүлэн, нийслэлийн гуравдугаар амаржих газар, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төв зэрэг байгууллагуудад зөрчил арилгуулах албан бичгийг хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна. Мөн Эрүүл мэндийн яамтай хамтран эрүүл мэндийн салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журмуудыг судлан, төлбөртэй тусламж, үйлчилгээний журмыг боловсруулж байна.

**Шударга ёсыг бага наснаас нь төлөвшүүлэх ажлыг эхлүүлээ.** Зорилтот бүлгийн нэгийг бага болон өсвөр насны хүүхдүүд гэж тодорхойлон шударга ёсыг бага наснаас нь төлөвшүүлэх ажлыг эхлүүлэв. АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр “Шударга мазаалайнууд”, “Найзын яриа” номуудыг тус бүр 1000 ширхэг хэвлүүлсэн бөгөөд нийслэлийн зарим сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд түгээж, номын утга санаа, агуулгыг түгээн дэлгэрүүлэхээр “Зуны даалгавар” арга хэмжээг зохион байгуулав. “Зуны даалгавар” арга хэмжээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурвалжлуулж, мэдээлэх ажлыг зохион байгуулсан нь шударга ёсны үзэл санааг хүүхэд багачуудад түгээн дэлгэрүүлэх үйлсэд бодит хувь нэмэр оруулсан хэмээн үзэж байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдын хувьд шударга байдлын түвшний ерөнхий үнэлгээ 2008, 2010, 2012 онуудад хийсэн судалгааны дүнгээр жил ирэх тутам буурч байгаа нь ёс зүй, ёс суртахуун, зан төлөвийн хувьд шударга бус байдалтай эвлэрэх, түүнд дасан зохицох, төлөвших хандлагатай байна хэмээн үзэж, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд ёс зүйг дээшлүүлэхэд анхаарах, шат дараалсан төлөвлөгөөт арга хэмжээ авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагад үндэслэн Хүүхдийн төлөө газартай хамтран ажиллалаа. Энэ ажлын хүрээнд 2013-2014 оны хичээлийн жилийн нээлтийн хичээлийг шударга ёс, ёс суртахууны чиглэлээр хүүхдүүдэд хүргэвэл шударга ёсны зан үйлийг хүүхэд багачуудад төлөвшүүлэх нөлөөллийн сайн арга хэмжээ болох талаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилснаар хичээлийн шинэ жилийн нээлтийг “Хуулийн засаглал ба хүүхдийн оролцоо” сэдвээр явуулсан болно. Энэхүү хичээлийн агуулгад хүүхдийн шударга байдлын түвшин буурч байгаа нь хүүхдүүдийн буруу зүйлийг зөв гэж үзэх хандлагаас шалтгаалдаг талаар тодорхой тусгагдсан асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч орон даяар хүргэсэн ач холбогдолтой арга хэмжээ болсон гэж үзэж байна.

**Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааг олон нийтэд хүргэх ажлыг төрөл бүрийн арга хэлбэрээр**



**явуулан, төрийн албан хаагч, олон нийтэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулав.** Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Авлигатай тэмцэх газрын бүрэн эрх, чиг үүргийн талаар тодорхой ойлголт өгөх зорилгоор “Авлигын эсрэг эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл”, “Монгол Улсын Их Хурлын гишүүн Танаа” гарын авлага, “Эрх бүхий албан тушаалтан Танаа” гарын авлагыг тус тус хэвлүүлэн түгээв. “Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн” төрийн бус байгууллагатай хамтран сургагч багш бэлтгэх болон нийтийн албан тушаалтнуудад зориулсан “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь: Сургагч багшийн гарын авлага”, “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь: Нийтийн албан тушаалтны гарын авлага”-ыг тус тус боловсруулан, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар видео хичээлийг бэлтгэв. Дэлхийн шилдэг эрэн сурвалжлах сэтгүүлчдийн авлигын нийгэмд үзүүлж байгаа хор хөнөөлийг таниулах зорилгоор бэлтгэсэн “Хятадын байгалийн бус гамшиг буюу Сичуань мужийн нулимс”, “Бидний мөнгө хаачив”, “Чишшшш, чимээгүй хэнд ч битгий хэлээрэй” зэрэг баримтат кинонуудыг монгол хэлнээ хөрвүүлэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийн хүртээл болгосон нь олон нийтэд чиглэсэн шинэлэг, ач холбогдолтой ажил боллоо. Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан таниулах ажилд мэргэжлийн урлагийн байгууллагуудыг татан оролцуулж, Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын Драм ангийн уран бүтээлчидтэй хамтран “Төлөөс” жүжгийг теле хэлбэрээр бүтээн олон нийтэд хүргэв. “Мерси Кор” олон улсын байгууллагатай хамтран “Авлигаас ангид, сайн засаглалын туршлага-2013” үйл ажиллагааг зохион байгуулж, төр, иргэний нийгмийн байгууллагуудаас сайн засаглалыг бэхжүүлэх зорилгоор 2013 онд авч хэрэгжүүлсэн “үйл ажиллагааг” нэр дэвшүүлэн цаашид түгээн дэлгэрүүлбэл зохих сайн туршлагыг шалгаруулав. “Мерси кор” олон улсын байгууллагатай хамтран залуусын дунд шударга ёсыг эрхэмлэх, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор анх удаа “Шударга нийгмийн төлөө хамтдаа” аяныг зохион байгууллаа. Энэ ажлын хүрээнд хүүхэд залууст зориулсан [www.Хамтдаа.mn](http://www.Хамтдаа.mn) вэб сайт, Хамтдаа.мн фэйсбүүк хуудсуудыг ажиллуулж байна. Мөн “Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэхэд оюутан залуусын оролцоо” сэдэвт Нийслэлийн аварга шалгаруулах парламентын мэтгэлцээний тэмцээн, “Авлигаас ангид нийгэм” зурагт хуудасны уралдаан, НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зам” /Асуудал ба шийдэл/ сэдэвт онол арга зүйн бага хурал, АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр “Шударга хүний долоон дадал” сэдэвт илтгэлийг 4900 гаруй оюутан, сурагчдад хүргэн, дэлхий нийтийн залуусын өдөр 12 дугаар сарын 7-нд “Шударга нийгмийн төлөө хамтдаа” парад алхаа зэрэг арга хэмжээг зохион байгуулсан болно.

Сүхбаатар дүүргийн ЗДТГ-аас “Сүхбаатарчууд бид авлигын эсрэг хамтдаа” дэвжээ тэмцээнийг, Булган, Өмнөговь аймгийн ЗДТГ, Худалдан авах ажиллагааны газар авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор асуулт хариултын “АХА” тэмцээнийг тус тус санаачлан амжилттай зохион байгууллаа. Мөн нийслэлийн Чингэлтэй, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нэг сарын аяны хүрээнд тусгай хөтөлбөр боловсруулан ажиллалаа. Булган аймгийн Олон нийттэй харилцах алба “Авлигын эсрэг хамтдаа: Бэрхшээл ба боломж” сэдэвт теле хэлэлцүүлгийг санаачлан Засаг даргын харьяа 16 агентлаг, газар, хэлтсүүдийн удирдах ажилтнуудын дунд зохион байгуулсан. Өмнөговь аймаг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Би шударга байж чадна” гар зургийн уралдааныг 3 насны ангиллаар зохион байгуулав. Удирдлагын академитай хамтран Нийслэлийн хороодын Засаг дарга нарт зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулан ажиллах зэргээр төрийн байгууллагуудын оролцоо, идэвхи санаачлага нэмэгдсэн гэж дүгнэж болохоор

байна. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагааг эхлүүлж, орон нутгийн сэтгүүлчдийн дунд шилдэг нийтлэл, нэврүүлгийн уралдаан зарлаж, шалгаруулах ажлыг зохион байгуулсан нь төрийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой ажил боллоо.

**Төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллалаа.** Тус байгууллага Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Зориг сан, Глоб интернэшнл төв, IRIM, Хэвлэлийн хүрээлэнгийн хойд бүсийн төв, АППИЙЛ хөтөлбөр, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо, Монголын эмэгтэйчүүдийн сан, Эмэгтэй удирдагч сан, Монголын нутгийн удирдлагын холбоо, MONPAC, Ардчилалын боловсрол төв /ДЕМО/ зэрэг 20 гаруй иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллаж, Авлигын эсрэг үндэсний стратегийн төслийг улсын хэмжээнд хэлэлцүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах сургагч багш бэлтгэх, сургалт явуулах, хуулийг сурталчлах 20 ангит цуврал кино бүтээх зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэв.

**Монгол Улсын Авлигын нөхцөл байдлыг судалж олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулав.** Авлигын эсрэг хуульд заасны дагуу авлигыг цар хүрээ, хэлбэр, шалтгаан гэсэн гурван талаас нь авч үзэн, авлигыг нэгдсэн тоон үзүүлэлтээр үндэсний түвшинд хэмжин гаргаж олон нийтэд мэдээллээ. Авлигын индекс 2013 оны байдлаар 0.65 гарсан нь 2011 оныхоос 0.02 пунктээр өссөн дүнтэй гарлаа. Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоолд зааснаар “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөлөл”-ийн үзүүлэлтийг 6 дахь удаагаа тооцон гаргасны зэрэгцээ Хүүхдийн шударга байдлын 2013 оны судалгааг Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээлэв.

## **1.2 ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ, ХАДГАЛАХ, ХЯНАН ШАЛГАХ ЧИГЛЭЛЭЭР**

### **Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний ажлын хүрээнд:**

Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/-ээ мэдүүлбэл зохих 278 төрийн өндөр болон түүнтэй адилтгах албан тушаалтны мэдүүлгийг цаасан болон цахим хэлбэрээр хуулийн хугацаанд 100 хувь хүлээн авч бүртгэн, нууцлалыг ханган хадгалж байна. Үүнээс **239** төрийн өндөр албан тушаалтан болон тэдгээртэй адилтгах албан тушаалтны 2012 оны мэдүүлгийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлүүлсэн болон тус газрын Олон нийтийн веб сайт /[www.xacxom.iaac.mn/](http://www.xacxom.iaac.mn/)-д байршуулж иргэд, олон нийтэд нээлттэй болгов.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2013 оны тайлан мэдээгээр улсын хэмжээнд 47000 орчим мэдүүлэг гаргагч бүртгэгдсэнээс **99,97** хувь нь хуулийн хугацаанд бүртгүүлж, 37 мэдүүлэг гаргагч буюу **0,03** хувь нь мэдүүлгээ гаргаж өгөөгүй, хугацаа хожимдуулсан, үүнээс 16 нь аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байгаа нь өмнөх жилүүдтэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

Мэдүүлгээ гаргаж өгөөгүй, хугацаа хожимдуулсан мэдүүлэг гаргагч нарт хариуцлага тооцуулах, мэдүүлгийг нөхөн гаргуулахаар тухайн байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад хандсан ба 31 мэдүүлэг гаргагчид сануулах, 2 мэдүүлэг гаргагчийг ажлаас чөлөөлж, нийт 33 /89,2 хувь/ мэдүүлэг гаргагчид сахилгын арга хэмжээг авахуулсан байна.

## Хүснэгт 2. Албан тушаалтнуудын мэдүүлгийн бүрдүүлэлт, оноор

Үзүүлэлт	ХОМ			ХАСХОМ	
	2009	2010	2011	2011	2012
Бүртгүүлбэл зохих мэдүүлэг гаргагчийн тоо	54000	56000	58000	45000	47000
Хугацаа хожимдуулж мэдүүлсэн	15	49	25	7	22
Огт бүртгүүлээгүй мэдүүлэг гаргагчийн тоо	136	69	64	96	15
Бүрдүүлэлтийн хувь	99.75	99.87	99.89	99.79	99.97

Улсын хэмжээнд мэдүүлэг гаргагчид мэдүүлгээ цахим хэлбэрээр мэдүүлэх [www.meduuleg.iaac.mn](http://www.meduuleg.iaac.mn), төрийн өндөр албан тушаалтны мэдүүлгийг ил тод, нээлттэй байх хүрээнд олон нийтийн цахим хуудас болох [www.xасxом.iaac.mn](http://www.xасxом.iaac.mn) зэрэг цахим хуудсыг ашиглалтад оруулж цахим хэлбэрээр мэдүүлгийг бүртгэх ажлыг улсын хэмжээнд анх удаа зохион байгуулав.

Цахим систем бий болсноор төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн салбар нэгжийн нийт 1500 орчим байгууллагад хадгалагдаж байгаа 47000 гаруй мэдүүлэг гаргагчдын мэдүүлгийн нэгдсэн мэдээллийн санг бий болгож мэдээллийг нэг дороос түргэн шуурхай авах, мэдүүлэг гаргагчдын сүүлийн 5 жилийн мэдүүлгийн мэдээллийг харах, харьцуулах, үүнд үндэслэн дүн шинжилгээ, судалгаа хийх, хяналт шалгалтын үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, мэдээ, тайланг Авлигатай тэмцэх газарт нэгтгэх, олон нийтийг үнэн бодит, шуурхай мэдээлэл авах боломжоор хангах, мэдүүлэг гаргагч мэдүүлгээ интернетийн орчин бүхий газраас мэдүүлж, энэ тухай мэдээллээ жил бүр шинэчлэн бүртгэх зэрэг ач холбогдолтой ажил боллоо.

Улсын хэмжээнд төрийн захиргааны болон нутгийн захиргааны 111 байгууллагад 117, түүний салбар нэгжид 1398, нийт мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах 1515 эрх бүхий албан тушаалтан ажиллаж байна. 2013 онд Төрийн захиргааны болон нутгийн захиргааны 111 байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах /117/ эрх бүхий албан тушаалтнуудын 39 хувь нь буюу 46 нь өөрчлөгдсөн байна. Шинээр томилогдсон эрх бүхий албан тушаалтнуудыг сургаж, мэргэшүүлэх зайлшгүй шаардлага үүсч байгаатай холбогдуулан “ЭБАТ-тай ярилцах цаг” уулзалт, ярилцлагыг тогтмол зохион байгуулж, нийслэлийн эрх бүхий албан тушаалтнуудын 70 орчим хувийг хамруулав.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн чиглэлээр 2013 онд давхардсан тоогоор 200 орчим байгууллагын 1423 эрх бүхий албан тушаалтан, 9557 мэдүүлэг гаргагч, бүгд 10980 албан тушаалтныг хамруулсан сургалтыг зохион байгуулсан нь нийт мэдүүлэг гаргагчдын 24 хувь нь болж байна.

“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан гарын авлага”, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагчид зориулсан гарын авлага”-ыг боловсруулж тус бүр 3000 хувийг хэвлүүлэн байгууллагуудад хүргүүлэн зөвлөмж өгч ажиллав.

**Хүснэгт 3. Мэдүүлгийн бүрдүүлэлт, бүрдүүлэлтийн дараахь хяналт шалгалтын үр дүнгээр хариуцлага тооцуулсан байдал, 2013 онд**


Д/д	Үзүүлэлт	Сануул-сан	Албан тушаалын цалинг бууруулсан	Албан тушаал бууруулсан	Ажлаас халсан	Бусад	Бүгд
1	Мэдүүлгийн бүрдүүлэлтээр	31	-	-	2	-	33
2	Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалт	33	14	5	1	14	67
	<b>Дүн</b>	<b>64</b>	<b>14</b>	<b>5</b>	<b>3</b>	<b>14</b>	<b>100</b>

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлын хүрээнд 2013 онд Үндэсний аудитын газар, Нийслэлийн аудитын газар, Улаанбаатар хотын хүрээнд байршилтай төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 47 аж ахуйн нэгж, Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон харьяа Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах алба, Нийслэлийн ЗДТГ-ын харьяа 7 агентлаг зэрэг байгууллагуудад бүрдүүлэлтийн хяналт, шалгалтын ажлыг хийж гүйцэтгэв. Бүрдүүлэлтийн хяналт шалгалтаар 2000 гаруй мэдүүлэг гаргагчийн 2011, 2012 оны ХАСХОМ-т хяналт хийж, мөн урьдчилсан мэдүүлэг хянуулаагүй томилогдсон 189 албан тушаалтныг чөлөөлж, түдгэлзүүлэн урьдчилсан мэдүүлгийг хянуулах арга хэмжээ авч ажиллав.

**Хяналт шалгалтын ажлын хүрээнд :**


2013 онд хяналт шалгалтын үйл ажиллагаанд Улсын бүртгэлийн ерөнхий газар, Зам тээврийн яамны бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг ашиглах, эрх авах асуудлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэн уг сангийн мэдээллийг ашиглаж байгаа нь үр дүнтэй ажил болж байгаа бөгөөд цаашид хууль хяналтын бусад байгууллага, татварын байгууллагын мэдээллийг ашиглах талаар хамтран ажиллахаар төлөвлөж байна. 2013 онд нийт 533 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгаснаас 363 нь төлөвлөгөөт хяналт шалгалтаар, 98 нь иргэд, байгууллагын гомдол, мэдээллээр, 96 нь тус газрын бусад хэлтсийн шугамаар хийгдсэн байна.

**Зураг 1. ХАСХОМ-ийн хяналт шалгалт**




Мэдүүлгийн хяналт шалгалтаар 52,2 хувь буюу 278 нь зөрчилгүй, 24,4 хувь буюу 130 нь хөрөнгө, орлогоо худал мэдүүлсэн, 15,2 хувь буюу 81 нь зөрчилтэй мэдүүлсэн боловч хариуцлага тооцуулах хэмжээнд хүрээгүй, 8,2 хувь нь буюу 44 нь хуулийн үйлчлэлд хамаарахгүй болсон байна.

**Зураг 2. ХАСХОМ-ийн хяналт шалгалтын үр дүн**




2013 онд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн нийт 311 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авснаас 216 буюу 69,4 хувийг хувь хүн, иргэнээс, 48 буюу 15,4 хувийг төрийн байгууллага, төрийн өмчит компани, аж ахуйн нэгжээс, 29 буюу 9,3 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, 18 буюу 5,7 хувийг нэргүй мэдээлэл эзэлж байна. Мөн тус газарт ирүүлсэн 311 гомдол, мэдээллийн 151 нь буюу 48,5 хувийг орон нутаг дахь байгууллага, албан тушаалтантай холбоотой өргөдөл, гомдол эзэлснээс Булган, Ховд, Хөвсгөл аймгийн төрийн байгууллага, албан тушаалтнуудтай холбоотой гомдол, мэдээлэл зонхилж байна.

**Зураг 3. Хүлээн авсан гомдол, мэдээлэл, субъектээр**



Өргөдөл, гомдол, мэдээллийг агуулгын хэлбэрээр нь авч үзвэл албаны эрх мэдлээ урвуулсан, хэтрүүлсэн, бусдад давуу байдал олгосон талаар 79 буюу 23,2 %-ийг, хууль тогтоомж зөрчсөн, хууль бус үйлдэл гаргасан талаар 64 буюу 20,5 %-ийг, албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан талаар 95 буюу 30,5 %-ийг, албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгуулах болон үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн талаар 48 буюу 15,4 %-ийг, бусад 25 буюу 8,3 %-ийг тус тус эзэлж байна.

**Зураг 4. Өргөдөл, гомдлын агуулга**



**2013 онд ирүүлсэн нийт 311 өргөдөл, гомдол, мэдээллээс 282 өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 1,1 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.** Хянан шийдвэрлэсэн 282 өргөдөл, гомдол, мэдээллийг зөрчлөөр нь авч үзвэл: Албан тушаалтны буруутай үйл ажиллагааг илрүүлж, хариуцлага тооцуулахаар шийдвэрлэсэн 45 буюу 15,9 хувийг, зөрчлийг арилгуулахаар эрх бүхий байгууллага албан тушаалтанд хандаж шийдвэрлүүлсэн 48 буюу 17,2 хувийг, хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар анхааруулсан буюу шаардлага хүргүүлсэн 51 буюу 18,1 хувийг, гомдолд дурдсан асуудал нь тогтоогдоогүй буюу зөрчил илрээгүй 53 буюу 18,7 хувийг, гэмт хэргийн шинжтэй зөрчлийг шалгуулахаар мөрдөн шалгах байгууллагад харъяаллын дагуу шилжүүлсэн 26 буюу 9,2 хувийг, Төрийн байгууллагад харъяаллын дагуу шилжүүлсэн 47 буюу 16,6 хувийг, хуульд заасан үндэслэлээр буцаасан 12 буюу 4,2 хувийг тус тус эзэлж байна.

**Зураг 5. Хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдол**



2013 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 10490 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч, 10338 этгээдийн

урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэв. Хянан шийдвэрлэсэн урьдчилсан мэдүүлгийг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 3,1 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй бөгөөд тэдгээрийн 40-41 хувийг хөдөө, орон нутгаас ирүүлсэн байна. Дээр дурдсан тоо баримтаас үзэхэд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь Авлигатай тэмцэх газарт хянуулах үүргээ биелүүлж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн хэвшиж байгаа нь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм. Мөн албан тушаалтны урьдчилсан мэдүүлгийг тус газраар хянуулахгүйгээр хууль зөрчин томилсон 320 гаруй этгээдийн тушаал, шийдвэрийг хүчингүй болгуулж, шийдвэрлэсэн байна.


### Зураг 6. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн хяналт



### Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд хариуцлага тооцуулсан талаар:

Хяналт шалгалтаар нийт 255 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан бөгөөд түүний дотор ажлаас халсан 26, албан тушаал бууруулсан 22, албан тушаалын цалинг 3 хүртэл сарын хугацаанд 30 хувиар бууруулсан 94, сануулсан 95, бусад арга хэмжээг 18 албан тушаалтанд тус тус тооцуулсан байна. Хяналт шалгалтын үр дүнгээр зөрчил гаргасан нийт 255 албан тушаалтанд хариуцлага тооцуулснаас 89 нь буюу 35 хувь нь орон нутаг дахь байгууллагын, 166 нь буюу 65 хувь нь Улаанбаатар хот дахь байгууллагуудын албан тушаалтан байна.

### Зураг 7. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн хүрээнд хариуцлага тооцуулсан тоо



### 1.3 ИРГЭД, БАЙГУУЛЛАГААС ИРСЭН ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ ХЯНАН ШАЛГАХ ЧИГЛЭЛЭЭР

Гэмт хэргийн шинжтэй 427 гомдол, мэдээлэл хүлээн авч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 172 дугаар зүйлд заасны дагуу хянан үзсэнээс 58 гомдол, мэдээлэл буюу 13.6 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 176 гомдол, мэдээлэл буюу 41.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргаж, 152 гомдол, мэдээлэл буюу 35.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн. 2012 оны мөн үетэй харьцуулахад шалгасан гомдол, мэдээлэл 18.4 хувиар өсч, шийдвэрлэлт 91.7 хувьтай байна.

#### Хүснэгт 4. Хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

	Гомдол, мэдээлэл	Дүнд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>427</b>	<b>100.0</b>
Эрүүгийн хэрэг үүсгэсэн	58	13.6
Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан	176	41.2
Харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн	152	35.6

Иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг байгууллага, салбараар авч үзвэл нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 103 /үүнээс 68 нь Засаг даргын үйл ажиллагаанд, 35 нь ЗДТГ-ын үйл ажиллагаанд/, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 72 /үүнээс 17 нь цагдаа, 6 нь прокурор, 6 нь шүүх, 12 нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, 6 нь мэргэжлийн хяналт, 11 нь гааль, 7 нь татвар, 5 нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, 2 нь тагнуул/ боловсрол, эрүүл мэнд, төрийн үйлчилгээний салбарт хамаарах 58 /үүнээс 27 нь боловсрол, 25 нь эмнэлэг, 6 нь улсын бүртгэлийн албанд/ газар, ашигт малтмалын салбарт хамаарах 23, яамдын үйл ажиллагаатай холбоотой 23, УИХ-ын гишүүнд холбоотой 4, төрийн болон орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хамаарах 51, банк санхүүгийн салбарт хамаарах 7, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хамаарах /хувийн хэвшил/ 40, бусад 46 гомдол, мэдээллийг ирүүлжээ.

#### Зураг 8. Иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийн тоо, гомдол, мэдээлэлд холбогдох байгууллага, салбараар ангилбал





Эрүүгийн хэрэг үүсгэсэн 58 гомдол, мэдээллийг гэмт хэргийн төрлөөр ангилбал төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах 19, төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 6, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах 6, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 3, хээл хахууль авах 8, хээл хахууль өгөх 10, хээл хахуульд зуучлах 1, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах 5 хэрэг бүртгэгдсэн.

Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан нийт гомдол, мэдээллийн 157-г Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар буюу гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр, 7 гомдол, мэдээллийг мөн хуулийн 24 дүгээр 24.1.2-т зааснаар буюу хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр, 12 гомдол, мэдээллийг мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4-т зааснаар буюу тухайн хэргийг урьд нь хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлал хүчинтэй байгаа үндэслэлээр тус тус эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай прокурорт хянуулж шийдвэрлэсэн.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаад эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гарган шийдвэрлэсэн үндэслэлийг судлан үзэхэд албан тушаалтан хууль бус үйлдэл хийж албаны эрх мэдлээ хэтрүүлсэн, урвуулсан үйлдлүүд тогтоогдсон боловч албан тушаалын эсрэг гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн болох үлэмж хэмжээний хохирол учраагүй 59, бодит хохирол нь үлэмж хэмжээнд хүрээгүй 26, тухайн асуудлыг урьд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тогтоол хүчин төгөлдөр болох нь тогтоогдсон 18, гэмт хэрэг үйлдэгдсэн болох нь тогтоогдоогүй 54 тохиолдол бүртгэгджээ.

Нийт шийдвэрлэсэн болон үлдэгдэл гомдол, мэдээллийн 259 нь Улаанбаатар хотоос, 168 нь хөдөө, орон нутгаас тус газарт шалгуулахаар ирүүлсэн.

#### **1.4 ХУУЛИАР ХАРЬЯАЛУУЛСАН ГЭМТ ХЭРЭГТ ЯВУУЛСАН МӨРДӨН БАЙЦААЛТЫН ЧИГЛЭЛЭЭР**

2013 онд хуульд заасан харьяаллын 499 үйлдэлтэй, 187 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь 2012 онтой харьцуулахад 12.7 хувиар өссөн байна.


Мөрдөн байцаалт явуулсан нийт хэрэг, үйлдлийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр ангилбал төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах хэрэг 70 гарсан нь өмнөх онтой харьцуулан үзэхэд 38.5 хувиар, төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх гэмт хэрэг 25 үйлдэгдэж 4 хувиар, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах гэмт хэрэг 19 үйлдэгдэж өмнөх онтой харьцуулахад 31.5 хувиар тус тус өссөн бол төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх гэмт хэрэг 3 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 66.6 хувиар, хээл хахууль авах гэмт хэрэг 22 бүртгэгдсэн нь 8.3 хувиар тус тус буурч, хээл хахууль өгөх гэмт хэрэг 20 бүртгэгдэж өмнөх онтой харьцуулан үзэхэд 5 хувиар, хээл хахуульд зуучлах гэмт хэрэг 8 бүртгэгдэж өмнөх оноос 50.0 хувиар тус тус өсчээ.

**Зураг 9. Мөрдөн байцаалт явуулсан нийт хэрэг, үйлдлийн тоо, Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр**



Мөрдөн шалгасан 187 эрүүгийн хэргээс 43 хэргийг буюу нийт шалгасан хэргийн 22.9 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр, 41 хэргийг буюу 21.9 хувийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар, 30 хэргийг буюу 16 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх санал гаргаж шийдвэрлүүлсэн.

**Зураг 10. Мөрдөн шалгасан эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийн тоо, 2013 он**



Яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн хэргийг төрлөөр нь авч үзвэл төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах 16, төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 5, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах 5, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 1, хээл хахууль авах 13, хээл хахууль өгөх 13, хээл хахууль зуучлах 4, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах 2, бусад 23 гэмт хэрэг нь прокурорын байгууллагад хүргүүлсэн.

Хэрэгсэхгүй болгогдсон 41 эрүүгийн хэргийн үндэслэлийг хэрэг тус бүрээр судлахад Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2-т заасан “хөөн хэлэлцэх хугацаа дууссан” үндэслэлээр 5 хэргийг, мөн хуулийн 24.1.1, 208 дугаар зүйлийн 208.1.2-т заасан “нотлох баримтыг цуглуулах бүхий л ажиллагааг хийсэн боловч сэжигтэн, яллагдагч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон болох нь

нотлогдоогүй буюу гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй” үндэслэлээр 32 хэргийг, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4-т заасан “урьд гаргасан хэрэгсэхгүй болгосон тогтоол хүчинтэй” үндэслэлээр 1 хэргийг тус тус хэрэгсэхгүй болгох санал гаргасан, 3 хэргийг прокурор татаж хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.

2013 оны жилийн эцэст 39 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан хэргийн 112 нь Улаанбаатар хотод, 75 нь хөдөө, орон нутгийн харъяалалтай, нэг мөрдөн байцаагч дунджаар эрүүгийн 9 хэрэгт ажиллагаа явуулсан дүнтэй ажилласан.

Эрүүгийн хэрэгт 400 хүн сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.5 хувиар өссөн ба холбогдогчдыг албан тушаалын байдлаар авч үзвэл төрийн улс төрийн албан хаагч 8.7 хувь буюу 35, төрийн захиргааны албан хаагч 21.2 хувь буюу 85, төрийн тусгай албан хаагч 11.5 хувь буюу 46, төрийн үйлчилгээний албан хаагч 10.5 хувь 42, энгийн буюу аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан 48 хувь буюу 192 хүн байна. 2013 онд нийт 23 хүнийг сэжигтэн, яллагдагчаар цагдан хорьсон бөгөөд 22 хүнийг яллагдагчаар, 1 хүнийг сэжигтнээр цагдан хорьсон.

**Зураг 11. Эрүүгийн хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдсан хүний тоо, албан тушаалын байдлаар, 2013 онд**



Эрүүгийн хэрэгт гадаадын 15 иргэн холбогдсон бөгөөд тэдгээрийн 11 нь БНХАУ-ын иргэн, 3 нь Австрали Улсын иргэн, 1 нь БНСУ-ын иргэн шалгагдсанаас 5 хүнд холбогдох хэргийн мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн, 3 хүнд холбогдох хэргийг харьяаллын дагуу шилжүүлсэн, 1 хүнд холбогдох хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн, 3 хүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон, одоо ажиллагаанд гадаадын 3 иргэн шалгагдаж байна.

Яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн 43 эрүүгийн хэрэгт 163 хүнийг яллагдагчаар татсан бөгөөд тэдгээрийг албан тушаалын төрлөөр нь авч үзвэл яам, агентлагийн албан тушаалтан 7, боловсролын салбарын албан тушаалтан 4, аймгийн Засаг дарга 1, сумын Засаг дарга 2, аймгийн Засаг даргын орлогч 5, аймгийн ИТХ-ын дарга 3, газрын албаны мэргэжилтэн 16, гаалийн улсын байцаагч 5, татварын улсын байцаагч 4, мэргэжлийн хяналтын улсын байцаагч 1, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн 1, төсөвт байгууллагын нягтлан бодогч 2, Засгийн газрын тусгай сан, сангийн удирдах ажилтан болон гүйцэтгэх албан тушаалтан 11, төрийн өмчит аж ахуйн нэгж болон төрийн бус байгууллагын албан тушаалтан 29, банк, санхүүгийн байгууллагын албан тушаалтан 13, бусад 59 хүн холбогдсон.

2013 онд шүүхээр шийдвэрлэгдсэн 11 хэргийг зүйлчлэлээр нь авч үзэхэд төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаар

урвуулах гэмт хэрэг 6, төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх гэмт хэрэг 1, хээл хахууль авах гэмт хэрэг 3, хээл хахууль өгөх гэмт хэрэг 3, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг 2, бусад 5 гэмт хэрэгт ял оноож шийтгэжээ.

Шүүхээр шийдвэрлэгдсэн 11 хэргийн 33 шүүгдэгчээс 26 шүүгдэгчийг шүүх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон, 14 шүүгдэгчийг хорих ялаар, 9 шүүгдэгчийг торгох ялаар, 3 шүүгдэгчийг баривчлах ялаар, 2 шүүгдэгчийг тодорхой ажил, албан тушаал эрхлэх эрхийг хязгаарлах нэмэгдэл ялаар шийтгэж, хорих ял оногдуулсан 10 шүүгдэгчийн ялыг тэнсэж хянан харгалзсан, 2 хэргийн 7 шүүгдэгчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч нарыг цагаатгаж шийдвэрлэсэн.

Мөрдөн шалгасан нийт эрүүгийн хэрэгт 85 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оноос 44.7 хувиар, 6.3 тэрбум төгрөгийн хохирлыг мөрдөн байцаалтын явцад нөхөн төлүүлсэн нь 50.7 хувиар, 17.1 тэрбум төгрөгийн эд зүйлийг битүүмжлэн хамгаалсан нь 77.1 хувиар тус тус өссөн.

## **1.5 ГАДААД ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР**

Авлигатай тэмцэх газар нь БНСУ-ын Авлигын эсрэг иргэний эрхийн хороо, БНХАУ-ын Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний товчоо, Тайландын Вант Улсын Авлигын эсрэг Үндэсний хороотой Харилцан ойлголцлолын санамж бичгийн хүрээнд хамтран ажиллаж, харилцан айлчлалууд зохион байгуулах, мэдээлэл солилцох, албан хаагчдыг сургалтад хамруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна. БНХАУ-д төвтэй Олон Улсын Авлигын эсрэг байгууллагуудын холбооноос зохион байгуулдаг чуулга уулзалт, семинарт төлөөлөгчид оролцуулж, харилцан туршлага солилцдог. Түүнчлэн авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Канад Улсын Хатан Хааны морьт цагдаагийн газар, АНУ-ын Хууль зүйн яам болон түүний харъяа Холбооны мөрдөх товчоо, Сингапурын Авлигын хэргийг мөрдөн шалгах товчоотой АТГ нь мэдээлэл солилцох, туршлага судлах чиглэлээр хамтран ажиллаж байна.

2013 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Монгол Улс Авлигын эсрэг олон улсын академийг олон улсын байгууллага болгон үүсгэн байгуулах тухай хэлэлцээр"-т нэгдэж, Академийн 64 дэх гишүүн орон болсон бөгөөд мөн оны 8 дугаар сард тус газар Авлигын эсрэг олон улсын академитай харилцан ойлголцлолын санамж бичиг байгуулж, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллахаар тогтон 2013 оноос эхлэн Академийн жил тутмын зуны сургалтад албан хаагчдаа хамруулж байна.

Монгол Улс нь 2012 оны 12 дугаар сард Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын Зүүн Европ, Төв Азийн авлигын эсрэг сүлжээний гишүүн болсон. Энэхүү сүлжээ нь гишүүн орнуудынхаа авлигатай тэмцэх чиглэлд авч хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагааг үнэлэн, үнэлгээнд суурилан зөвлөмж өгч, шат дараалсан арга хэмжээг авч ажилладаг. Одоогоор Монгол Улсын авлигатай тэмцэх үйл ажиллагаанд үнэлгээ өгсөн тайлангийн төслийг ирүүлээд байгаа бөгөөд Хууль зүйн яам болон Авлигатай тэмцэх газрын төлөөлөгчид 2014 оны 4 дүгээр сард Франц Улсын Парис хотод зохион байгуулагдах Авлигын эсрэг хууль сахиулах байгууллагуудын сүлжээний 4 дэх удаагийн уулзалт, Авлигын эсрэг сүлжээний удирдах зөвлөлийн 16 дугаар хурлын үеэр тайлангаа хамгаалснаар үнэлгээний эцсийн дүн гарна.

Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг үр дүнтэй хэрэгжүүлэх, Монгол Улсын авлигын индексийн судалгааны аргачлал, түүнд дүн шинжилгээ хийх болон ашиглалтыг сайжруулах зорилгоор Авлигаас

урьдчилан сэргийлэх ажиллагаа, хяналт шалгалтыг бэхжүүлэх төслийг Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж эхлэв.

Дэлхийн банк, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын хамтарсан төсөл болох "Хулгайлагдсан хөрөнгийг буцаах санаачилга" (СТАР)-тай хамтран ажиллах хүрээнд тус байгууллагын төлөөлөгчид Монгол Улсад хуваарьт ажлын айлчлалуудыг хийж, дотоодод болон олон улсын хэмжээнд хулгайлагдсан хөрөнгийг мөрдөх, битүүмжлэх, хураах, буцаах ажиллагааг хялбарчлахад чиглэгдсэн Авлигатай тэмцэх газар болон бусад холбогдох байгууллагуудын үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчинг сайжруулахад дэмжлэг болох богино болон дунд хугацааны арга хэмжээнүүдийг тодорхойлж, тэдгээртэй холбогдох зөвлөмжүүдийг өгсөн болно. 2013 онд "Санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах", "Эрх зүйн харилцан туслалцаа хүссэн захидал боловсруулах" сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан. Үүнээс гадна СТАР-ын төлөөлөгчид хууль сахиулах байгууллагуудын төлөөлөлтэй хамтран семинар зохион байгуулж, Эрх зүйн харилцан туслалцааны гарын авлагыг боловсруулсны зэрэгцээ СТАР-ын зөвлөхүүд АТГ-ын мөрдөн байцаагчдад мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, гадны байгууллагууд болон мэргэжилтнүүдтэй холбох ажлыг зохион байгуулж байна.

## ХОЁР. МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс дахь авлигын нөхцөл байдлыг тодорхойлох дотоодын болон олон улсын байгууллагын олон төрлийн судалгаа хийгддэг. Монгол Улсын авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх олон улсын байгууллагуудын үнэлгээ болон үндэсний хэмжээнд хийгддэг бусад судалгааны үр дүнд үндэслэн авлигын ерөнхий нөхцөл байдлыг тодорхойлон танилцуулж байна.

### **2.1 АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС<sup>1</sup>**

Олон улсын хэмжээнд дэлхийн улс орнуудын авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөж байгааг харьцуулан үнэлгээ гаргадаг “Транспарэнси Интернэшнл” байгууллагын Авлигын төсөөллийн индекс (АТИ)-ийг 1995-2011 оны хооронд 0-10 хүртэл оноогоор үнэлдэг байсныг 2012 оноос эхлэн 0 (авлигад маш ихээр автсан), 100 (авлигагүй) хүртэл оноогоор үнэлдэг болсон юм. Авлигын төсөөллийн индексийн судалгааны аргачлал ийнхүү 2012 онд өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2012, 2013 оны судалгааны дүнг харьцуулахуйц болсон нь энэ удаагийн судалгааны нэгэн онцлог бөгөөд 2013 оны судалгаагаар манай улс 38 оноо авч судалгаанд хамрагдсан 177 орноос 83 дугаар байрт орсон байна. Судалгааны үр дүнг 2012 оныхтой харьцуулахад АТИ-ийн утга 2 пунктээр нэмэгдэж, эзлэх байр 11-ээр ахисан эерэг үзүүлэлттэй байна. АТИ-ийн 2013 оны судалгаанд 177 орныг хамруулснаас Монгол Улсын хувьд Авлигын төсөөллийн индексийн утга 38 гэсэн үнэлгээгээр Буркино Фасо, Эл Славатор, Ямаик, Либер, Перу, Тринада Табаго, Замби зэрэг улсуудын хамт 83 дугаар байрт орсон юм. Судалгааны дүнгээс харахад Дани, Шинэ Зеланд, Финланд, Швед, Норвеги, Сингапур, Швейцарь, Нидерланд, Австрали, Канад Улсууд тэргүүлсэн байна. Харин хөрш ОХУ 28 оноотойгоор 127 дугаар байрт орсон бол БНХАУ 39 оноотой 80 дугаар байрт тус тус орсон байна.

### **Хүснэгт 5. Авлигын төсөөллийн индексийн утга болон үнэлгээнд хамрагдсан улс орнууд дунд эзлэх байр**

	2006	2007	2008	2009	2010	2011	2012 <sup>2</sup>	2013
Авлигын төсөөллийн индексийн утга	2.8	3.0	3.0	2.7	2.7	2.7	36	38
Монгол Улсын эзэлж буй байр	99	99	102	120	116	120	94	83
Үнэлгээнд хамрагдсан улс орны тоо	163	179	180	180	178	182	176	177

Монгол Улсыг үнэлэхдээ нийт 7 мэдээллийн эх үүсвэр ашиглаж үнэлгээ хийсэн байна. Үнэлгээнд ашигласан 7 мэдээллийн эх үүсвэрийг өмнөх оныхтой харьцуулахад Дэлхийн эрх зүйн төслийн Эрх зүйт ёсны дэлхийн индекс 4 пунктээр буурсан хэдий ч “Бертелсман” сангийн Шилжилтийн индекс 8 пунктээр, Дэлхийн эдийн засгийн форумын Үзэл бодлын судалгааны үнэлгээ 6 пунктээр тус тус өссөн нь авлигын төсөөллийн индекс 2 пунктээр нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

<sup>1</sup> <http://www.transparency.org/cpi2012/results> (хандалт 2013 оны 1 дүгээр сарын 21-ны өдөр)

<sup>2</sup> 2012 оноос эхлэн үзүүлэлтийг 0-100 оноогоор дүгнэдэг болсон.

## 2.2 ДЭЛХИЙН НИЙТИЙН АВЛИГЫН ХЭМЖҮҮР СУДАЛГАА<sup>3</sup>

“Транспарэнси Интернэшнл” байгууллага Дэлхий нийтийн авлигын хэмжүүр (ДНАХ) судалгааг явуулдаг. ДНАХ судалгаа нь авлигын талаар олон нийтийн төсөөллийн хамгийн өргөн хүрээтэй, том судалгаа бөгөөд судалгаанд оролцсон хүмүүсийн авлига, хээл хахуультай холбоотой үзэл бодол, төсөөлөл, тухайн улсын хамгийн их авлигатай институц, авлигатай тэмцэх хүсэл сонирхол зэргийг судалдаг. Монгол Улс 2009, 2010, 2012/2013 оны судалгаанд хамрагдсан байна. Тус байгууллага 2013 оны судалгаандаа манай улсаас 1000 иргэнийг хамруулжээ. Судалгаанд оролцогч иргэдийн 86 хувь нь Монгол Улсад авлига ноцтой асуудал гэж үзсэн байна. Судалгааны үндсэн үр дүнг харуулав.

### Хүснэгт 6. Дэлхий нийтийн авлигын хэмжүүр судалгааны дүн

Д/Д	Асуулт	Хариулт /судалгаанд оролцогчдын хувь/
1	Сүүлийн хоёр жилийн хугацаанд Монгол Улсын авлигын түвшин хэрхэн өөрчлөгдсөн вэ?	Их өссөн -28% Өссөн-20% <b>Өөрчлөгдөөгүй-32%</b> Буурсан-18% Маш их буурсан-1%
2	Монгол Улсын төрийн байгууллага дахь авлига ямар түвшний асуудал вэ?	<b>Ноцтой асуудал-86%</b> Асуудал-7% Бага асуудал-5% Ямар ч асуудал биш-2%
3	Төр засгаас авлигатай тэмцэхээр явуулж байгаа бодлого, арга хэмжээг хэрхэн үнэлэх вэ?	Маш үр дүнтэй-2% Үр дүнтэй-23% <b>Үр дүнтэй ч биш/ үр дүнгүй ч биш-36%</b> Үр дүнгүй-28% Ямар ч үр дүнгүй-11%
4	Монгол Улс дахь авлига хамгийн их тархсан институц аль нь вэ?	<b>Улс төрийн намд-65%</b> <b>УИХ/ хууль тогтоох байгууллагад-63%</b> Цэрэг/армид-27% Төрийн бус байгууллагад-16% Хэвлэл мэдээлэлд-39% Шашны байгууллагад-11% Бизнесийн байгууллагад-45% <b>Боловсролын системд-63%</b> <b>Шүүх засаглалд-73%</b> <b>Эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээнд-71%</b> <b>Цагдаад-66%</b> <b>Төрийн албан хаагчдад-77%</b>
5	Сүүлийн 12 сарын хугацаанд танай өрхийн хэн нэгэн төрөөс дараах үйлчилгээг авахдаа хээл хахууль өгсөн үү?	<b>Боловсролын үйлчилгээнд -34%</b> <b>Шүүхийн үйлчилгээнд -35%</b> <b>Эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээнд-35%</b> <b>Цагдаагийн байгууллагын үйлчилгээнд-39%</b> Газрын албаны үйлчилгээнд -21% Татварын байгууллагын үйлчилгээнд -22% Бүртгэл, зөвшөөрөл олгох үйлчилгээнд-19% Нийтийн үйлчилгээнд-8%

Судалгааны дүнгээр Монгол Улсад авлига хамгийн их тархсан институцээр Төрийн албан хаагчид, Шүүх засаглал, Эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээ, Улс төрийн нам, Боловсролын систем зэргийг нэрлэсэн байна. Судалгаанд оролцогчдын 39 хувь нь цагдаад, 35 хувь нь шүүх, эрүүл мэнд, эмнэлгийн


<sup>3</sup> Global Corruption Barometer

үйлчилгээнд, 34 хувь нь боловсролын үйлчилгээнд сүүлийн 12 сарын хугацаанд хээл хахууль өгсөн гэж хариулсан байна.

### 2.3 МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ИНДЕКС

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу Авлигатай тэмцэх газар авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан Авлигын индексийг тооцон гаргаж олон нийтэд мэдээлдэг. Монгол Улсын Авлигын индекс 2013 оны байдлаар **0.65**<sup>4</sup> гарсан нь 2011 оныхоос 0.02 пунктээр өссөн эерэг дүнтэй гарлаа. Энэ нь сүүлийн хоёр жилийн хугацаанд Монгол Улс дахь авлигын түвшин 0.02 пунктээр буурсан болохыг илэрхийлж байна.

**Зураг 12. Монгол Улсын Авлигын индекс, оноор**



Авлигын индексийн тооцоолол нь 1/цар хүрээ, 2/хэлбэрийн гэсэн хоёр дэд үзүүлэлтээс бүрддэг.

Авлигын цар хүрээний үзүүлэлт 2011, 2013 оны судалгаагаар тогтмол 0.74 гарсан нь авлига хэмээх гэмт үзэгдэл тодорхой хэмжээнд оршсоор байгаа ч цар хүрээ нь өөрчлөгдөөгүй буюу цааш тэлэх боломж олгоогүй болохыг харуулж байна.

Авлигын индексийн хэлбэрийн үзүүлэлтийн хувьд 2013 онд 0.55 гарсан нь 2011 оныхоос 0.03 пунктээр өссөн эерэг дүнтэй байна.

**Зураг 13. Монгол Улсын Авлигын индексийн дэд үзүүлэлт, оноор**



**Авлигын цар хүрээ:** Авлигын цар хүрээг дөрвөн дэд үзүүлэлтээр дүгнэдэг. Дэд үзүүлэлт тус бүрээр нь авч үзвэл:

1/ Авлигын цар хүрээний талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт 2013 онд 0.80 болсон нь судалгаанд хамрагдсан олон нийт, шинжээчдийн 80.0 хувь нь Монгол Улсад авлига түгээмэл гэж үзсэнийг илтгэж байна. Энэ нь өмнөх судалгааны үр дүнгээс 1.0 пунктээр нэмэгджээ.

2/ Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт 2013 онд 0.02 буюу өмнөх судалгааны дүнтэй адил байна. Энэ нь улсын нэгдсэн төсвийн зарлагын 2.0 хувьтай тэнцэх хэмжээний хохирлыг авлигын гэмт хэргийн улмаас учруулсан болохыг баримтын судалгаа харуулж байна.

<sup>4</sup> Авлига хэмээх сөрөг үзэгдлийн цар хүрээ, хэлбэр, шалтгааныг тодорхойлох тоон болон чанарын үзүүлэлтүүдийн нийлбэр цогцыг авлигын индекс гэж ойлгоно.



### Хүснэгт 7. Авлигын цар хүрээний үзүүлэлт, дэд үзүүлэлтээр


Үзүүлэлт		2011	2013	Өөрчлөлт
Авлигын цар хүрээний нэгдсэн үзүүлэлт		0.74	0.74	0.00
1	Авлигын цар хүрээний талаарх олон нийт, шинжээчдийн төсөөллийн үзүүлэлт	0.79	0.80	0.01
2	Авлигын эдийн засгийн үр дагаврын үзүүлэлт	0.02	0.02	0.00
3	Шинжээчдийн төсөөллөөрх авлигын хувь хэмжээ	0.11	0.09	-0.02
4	Олон нийтийн зүгээс төрийн албан хаагчдад өгсөн хээл хахуулийн дундаж хувь хэмжээ	0.13	0.13	0.00

3/ Шинжээчдийн төсөөллөөр авлигын хувь хэмжээний үзүүлэлт 0.09 гарсан нь 2011 оныхоос 0.02 пунктээр буурсан буюу төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт хамрагдах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалтад ялах, өр төлбөр, иргэний нэхэмжлэлийг шийдвэрлүүлэх, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх зэрэг хэлцлүүдийн үнийн дүнгийн дунджаар 9.0 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг 2013 онд авлига, хээл хахууль байдлаар зарцуулсан гэж шинжээчид үзсэнийг харуулж байна.

4/ Олон нийтийн төсөөллийн судалгаанд хамрагдсан иргэдийн 17.4 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулсан нь өмнөх судалгааны дүнгээс 2.6 пунктээр буурсан эерэг үзүүлэлттэй байна. Тэдгээр иргэд өрхийнхөө жилийн орлогын дунджаар 13.0 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийг хээл хахууль байдлаар зарцуулсан гэж үзжээ.

**Авлигын хэлбэр:** Авлигын хэлбэрийн үзүүлэлт 0.55 гарсан нь өмнөх судалгааны дүнгээс 0.03 пунктээр өссөн байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу тус газар нь Эрүүгийн хуулийн 263/Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах/, 264/Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, 265/Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах/, 266/Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх/, 268/Хээл хахууль авах/, 269/Хээл хахууль өгөх/, 270/Хээл хахуульд зуучлах/, 270<sup>1</sup>/Хууль бусаар хөрөнгөжих/, 273/Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/ дугаар зүйлд заасан 9 төрлийн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулдаг.

#### Зураг 14. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, /2010-2013 онд, дүнд эзлэх хувиар/



Монгол Улсад Авлигатай тэмцэх газар болон Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба (хуучин нэрээр)-нд шалгасан авлига, албан тушаалын 9 төрлийн гэмт хэргийн дүнд эзлэх хувиар авч үзвэл 2012-2013 онд

шалгагдсан нийт гэмт хэргийн хамгийн их буюу 34.5 хувийг төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэрэг, 15.3 хувийг төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх, 14.6 хувийг хээл хахууль авах, 12.2 хувийг хээл хахууль өгөх, 10.5 хувийг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах, 12.9 хувийг авлига, албан тушаалын бусад гэмт хэрэг эзэлж байна.

2012-2013 онд шалгагдсан авлига, албан тушаалын гэмт хэргийн хувийн жинг 2010-2011 оныхтой харьцуулахад төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах 8.7 пунктээр, хээл хахууль авах 13.3 пунктээр тус тус буурсан байхад төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 3.9 пунктээр, бусад гэмт хэрэг 4.2 пунктээр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах 5.3 пунктээр, хээл хахууль өгөх 8.7 пунктээр тус тус нэмэгдсэн болохыг судалгааны дүн харуулж байна.

**Авлигын шалтгаан нөхцөл:** Авлигын индексийн судалгааны Шинжээчдийн болон Олон нийтийн төсөөллийн судалгаанд оролцогч шинжээч, иргэн, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдээс Монгол Улсад авлига үүсгэж буй шалтгаан нөхцөлийг асуухад дараахь шалтгаануудыг нэрлэсэн байна.

**Хүснэгт 8. Авлигын шалтгаан нөхцөл, шинжээчдийн болон олон нийтийн төсөөллийн судалгаа /хамгийн их нэрлэсэн шалтгаан нөхцөлөөр/**

Шинжээч	Иргэд	Төрийн албан хаагч	Бизнес эрхлэгч
Улс төрийн нөлөө их	Улс төрийн нөлөө их	Улс төрийн нөлөө их	Улс төрийн нөлөө их
Ашиг сонирхлын зөрчил их	Ашиг сонирхлын зөрчил их	Ашиг сонирхлын зөрчил их	Ашиг сонирхлын зөрчил их
Төрийн албан хаагчдын цалин, орлого бага	Цалин, орлого бага	Төрийн албан хаагчдын цалин, орлого бага	Цалин, орлого бага
Эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул	Эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул	Эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул	Эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул
Хүмүүсийн сэтгэлгээ, ухамсрын түвшин муу, ёс зүйгүй байдал	Ажлаа хурдан бүтээхийн тулд	Хүмүүсийн сэтгэлгээ, ухамсрын түвшин муу, ёс зүйгүй байдал	Хүмүүсийн сэтгэлгээ, ухамсрын түвшин муу, ёс зүйгүй байдал
Хариуцлага тооцдоггүй, хөндлөнгийн хяналт сул	Ажилгүйдэл, ядуурал	Ажилгүйдэл, ядуурал	Төрийн үйлчилгээний хүртээмж муу

Шинжээч, иргэн, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдийн үзсэнээр улс төрийн нөлөө болон, ашиг сонирхлын зөрчил их, төрийн албан хаагчдын цалин, орлого бага, эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул байгаа нь Монгол Улсад авлига үүсэхэд хамгийн ихээр нөлөөлж буй шалтгаан гэж үзэж болохоор байна.


Түүнчлэн шинжээч, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдийн үзэж байгаагаар хүмүүсийн сэтгэлгээ, ухамсрын түвшин муу, ёс зүйгүй байдал давамгайлсан нь авлига үүсэх бас нэгэн шалтгаан болохыг харууллаа. Хариуцлага тооцдоггүй, хөндлөнгийн хяналт сул байгааг авлига үүсэхэд хамгийн ихээр нөлөөлж буй шалтгаан гэж шинжээчид дүгнэсэн бол иргэн, төрийн албан хаагчийн төсөөллөөр ажилгүйдэл, ядуурал, харин бизнес эрхлэгчдийн төсөөллөөр төрийн үйлчилгээний хүртээмж муу байгаа нь авлига үүсэх шалтгаан болж байгаа нь харагдаж байна.

**Авлигад өртөх эрсдэл /аймаг, нийслэл, салбараар/:** Авлигатай тэмцэх газраас Авлигын индексийг үндэсний түвшинд тооцон гаргахын зэрэгцээ авлигад өртөх эрсдлийг 1/ аймаг, нийслэлээр буюу нутгийн захиргааны ба нутгийн өөрөө удирдах байгууллагаар, 2/ салбараар тооцон гаргадаг билээ. Энэ нь аймаг,

нийслэл, салбаруудыг авлигад өртөх эрсдлээр нь үнэлэлт, дүгнэлт өгөх боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд авлигад өртөх эрсдлийг тооцохдоо авлигыг үүсгэгч хүчин зүйлс болон бодит байдлын талаарх шинжээчид, төрийн албан хаагч, иргэн, бизнес эрхлэгчийн санаа бодлыг тусгасан 14 төрлийн шалгуур үзүүлэлтийг ашигласан болно.

Авлигад өртөх эрсдэл өндөртэй аймаг, нийслэлд 2013 оны байдлаар Завхан аймаг 0.54, Хөвсгөл 0.47, Улаанбаатар хот 0.45, Баян-Өлгий 0.44, Төв, Сэлэнгэ аймаг 0.42 үнэлгээтэй орсон байхад авлигад өртөх эрсдэл багатай аймагт Сүхбаатар 0.23, Архангай 0.27, Өвөрхангай, Булган, Говь-Алтай аймгууд 0.31 гэсэн үнэлгээтэй орсон байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад авлигад өртөх эрсдэл Улаанбаатар хот, Төв, Сэлэнгэ, Завхан аймгуудад 0.03-0.17 пунктээр өссөн, Хэнтий, Хөвсгөл аймагт тогтвортой, бусад 16 аймагт 0.01-0.12 пунктээр буурсан дүнтэй байна.

**Зураг 15. Авлигын индекс болон авлигад өртөх эрсдэл, /аймаг, нийслэлээр, 2013 онд/**



Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан бүтцийн дагуу Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудлын хүрээний салбарын авлигад өртөх эрсдэл, авлигын индексийг тооцон гаргав.

2013 оны байдлаар Эрүүл мэндийн сайдын салбар 0.44, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын салбар 0.42, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын салбар 0.38, Барилга, хот байгуулалтын сайдын салбар 0.38, Зам, тээврийн сайдын салбар 0.37 гэсэн үнэлгээтэй буюу авлигад өртөх эрсдэл өндөр байгаа бол Хөдөлмөрийн сайдын салбар 0.28, Гадаад харилцааны сайдын болон Хууль зүйн сайдын салбарууд тус бүр 0.30, Эрчим хүчний сайдын болон Эдийн засгийн хөгжлийн сайдын салбарууд тус бүр 0.32 гэсэн үнэлгээ авсан нь бусад салбартай харьцуулахад авлигад өртөх эрсдэл харьцангуй бага байна гэж судалгаанд оролцогч, шинжээчид дүгнэсэн байна.

**Зураг 16. Авлигын индекс болон авлигад өртөх эрсдэл,  
/Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудлын хүрээгээр, 2013 онд/**



Салбарын авлигатай тэмцэх үйл ажиллагааны үр ашиг яамдын түвшинд харьцангуй өндөр хувьтай байгаа бол харин яамдаас доогуур түвшинд /агентлаг, төрийн захиргааны байгууллагын орон нутаг дахь салбар нэгж, нутгийн захиргааны ба нутгийн өөрөө удирдах байгууллага/ бага хувьтай байна.

Сүүлийн 6 жилийн дунджаар хамгийн их авлигад автсан гэж олон нийтийн төсөөлж байгаа институцээр шүүх, хууль хяналтын байгууллага, улс төрийн нам нэрлэгдсэн байна. Судалгаанд оролцогч олон нийтээс сүүлийн 12 сарын хугацаанд төрийн албан хаагчдад ямар нэгэн хэлбэрээр хээл хахууль өгсөн эсэхийг асуухад 2013 оны байдлаар иргэдийн 17.4 хувь, төрийн албан хаагчдын 9.1 хувь, бизнес эрхлэгчдийн 11.9 хувь төрийн албан хаагчдад хээл хахууль өгсөн гэж хариулсан бөгөөд энэ дүн 2009, 2011 оны судалгааны дүнтэй ойролцоо түвшинд байна. Энэ нь нөгөө талаасаа олон нийтийн дунд хууль, эрх зүйн мэдлэг хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Олон нийтийн зүгээс төр, засгийн авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үр дүнтэй гэж үзэх байдал 2011 оны судалгаагаар буурах хандлагатай байсан бол энэ удаагийн судалгаагаар төр, засгийн авлигатай тэмцэх үйл ажиллагааг үр дүнтэй гэж үзэх олон нийтийн хувийн жин нэмэгдсэн байна. Улмаар олон нийтийн төсөөлж байгаагаар өнгөрсөн хоёр жилийн хугацаанд Монгол Улс дахь авлигын түвшин буурсан гэж үзсэн хүмүүсийн тоо өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад нэмэгдсэн байна. Мөн ирэх хоёр жилийн хугацаанд Монгол Улс дахь авлигын түвшний талаарх тэдний төсөөлөл сайжирч авлигын түвшин буурна гэж үзэх хандлага нэмэгдсэн нь эерэг үзүүлэлт болж байна.

Авлигын индексийн 3 удаагийн судалгаагаар авлига түгээмэл гэж үзэж буй шинжээчдийн хувь хэмжээ буурахгүй байгаа дүр зураг ажиглагдаж байна. Тухайлбал, төрийн байгууллага дахь албан тушаалын хууль бус томилгоо, төрийн албан хаагчдын ашиг сонирхлын зөрчил, төрийн байгууллагын ил тод бус байдал, хариуцлага тооцох механизм сул зэрэг нь авлига түгээмэл байна гэж үзэхэд нөлөөлсөн байна.

Авлигатай тэмцэх газар байгуулагдсан цагаас эхлэн төрийн байгууллагууд авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх стратеги төлөвлөгөөтэй байх асуудлыг хөхиүлэн дэмжиж, төрийн байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгч

ажиллаж ирсэн хэдий ч тухайн салбарт энэ төрлийн төлөвлөгөө байдаггүй гэж үнэлж буй шинжээчдийн хувь хэмжээ төдийлөн буурахгүй байгаа нь стратеги төлөвлөгөөгөө сурталчилдаггүй, энэхүү төлөвлөгөө нь тунхаглалын шинж чанартай, нэр төдий, түүнчлэн доод шатны байгууллагууддаа хүрдэггүй зэрэгтэй холбоотой байж болох юм. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа энэ талаар хийгдэж байгаа судалгаа, шинжилгээний ажлын дүнг ашиглах, улмаар судалгаа шинжилгээний дүнд үндэслэсэн шийдвэр гаргах явдал дутмаг байгааг судалгааны дүн харууллаа.

Салбаруудын удирдах албан тушаалтнуудын дунд 2009 оноос хойших хугацаанд ашиг сонирхлын зөрчил буурах хандлага ажиглагдахгүй байна.

Тендер шалгаруулалт буюу төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг шинжээчдийн 9.1 хувь нь ил тод, шударга хийгддэг гэж үзсэн бол 33.5 хувь нь зарим тохиолдолд ил тод, шударга байдаг, 40.6 хувь нь огтхон ч ил тод, шударга байдаггүй гэж үзсэн байна. Энэ нь төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалт хангалттай түвшинд ил тод, шударга хийгдэж чадахгүй байгааг илэрхийлж байна.

Хөндлөнгийн хяналт мониторинг хийх, эрсдэл бүхий албан тушаалын сэлгээ хийх, албан хаагчдын зүй бус үйлдлийн талаар иргэдээс мэдээлэл авах зэрэг асуудлын хувьд зарим нэг эерэг чиг хандлага ажиглагдаж байгаа хэдий ч эдгээр асуудлыг зохицуулж буй дүрэм журмыг иргэд, олон нийтэд сурталчлах, дүрэм, журмыг хянан үзэж, боловсронгуй болгох зэрэг ажлууд хангалттай түвшин хийгдэхгүй байна.

#### **2.4 ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШНИЙ ҮНЭЛГЭЭ:**

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх”-ээр заасны дагуу судалгааг 2012 онд зохион байгуулан судалгааны үр дүнд үндэслэн төрийн үйлчилгээний 10 салбарын шударга байдлын түвшинг тодорхойлсон. Төрийн үйлчилгээний салбаруудын дунджаар төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ (1-5 хүртэлх үнэлгээгээр) 3.38 гарсан нь 2010 оны судалгааны үр дүнгээс 0.61 пунктээр өссөн эерэг үзүүлэлт болж байна<sup>5</sup>.

#### **Хүснэгт 9. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ**

Салбар	Шударга байдлын түвшний үнэлгээ		Зөрүү
	2010	2012	
Эрүүл мэндийн байгууллага	2.70	3.24	0.54
Боловсролын байгууллага	2.88	3.54	0.66
Хөдөлмөр, халамж үйлчилгээний байгууллага	2.84	3.40	0.56
Нийгмийн даатгалын байгууллага	2.91	3.61	0.70
Газрын алба	2.70	3.22	0.52
Татварын байгууллага	2.99	3.58	0.59
Улсын бүртгэлийн байгууллага	2.73	3.36	0.63
Гаалийн байгууллага	2.89	3.83	0.94
Мэргэжлийн хяналтын байгууллага	2.80	3.32	0.52
Цагдаагийн байгууллага	2.70	3.19	0.49
<b>Төрийн байгууллагуудын дундаж</b>	<b>2.77</b>	<b>3.38</b>	<b>0.61</b>


<sup>5</sup> “Монгол Улсын төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх 2012 оны судалгааны тайлан”, Авлигатай тэмцэх газар, Улаанбаатар хот. 2012 он.

Энэ үнэлгээ нь 1-ээс 5 хүртэлх үзүүлэлтээр (1-ийг туйлын шударга бус, 5-ыг маш шударга гэж ойлгож болно) гардаг учир төрийн байгууллага бүхэлдээ хэр шударга, ил тод, хариуцлагатай байгааг харж болно. Төрийн байгууллагын шударга байдлыг үнэлэх судалгааг 2 жил тутамд 1 удаа зохион байгуулдаг тул дараагийн судалгаа 2014 онд явагдана.

## 2.5 УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ АВЛИГЫН ТӨСӨӨЛӨЛ:

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоолд Монгол Улсын Мянганы хөгжлийн 9 дэх зорилгын “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд хэвшүүлэх” 24 дүгээр зорилтын шалгуур үзүүлэлт “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөлөл”-ийн үзүүлэлтээр үнэлдэг билээ. Авлигатай тэмцэх газраас “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөллийн судалгаа”-г 6 дахь удаагаа тооцон гаргаад байна. Судалгаагаар Монгол Улсын улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн 2013 оны үнэлгээ 3.68 байна. Үүнийг 2012 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 0.25 пунктээр буурчээ. Гэвч энэ үзүүлэлт нь улс төр, хууль хяналтын хүрээнд авлига түгээмэл оршсоор байгааг илэрхийлж байна.

**Зураг 17. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн үнэлгээ**



Улс төрийн авлигын олон хэлбэрүүдээс нам болон сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой, ялангуяа намын болон сонгуулийн санхүүжилтийн асуудал илүү ноцтой гэж үзсэн байна.


Төрийн албан тушаалтнаар өөрт ашигтай, давуу тал бий болгох шийдвэр гаргуулахын тулд олон янзын арга зам хэрэглэдэг боловч тухайн албан тушаалтанд мөнгө хөрөнгө өгөх, түүнийг албан тушаалд томилох, цалин өндөртэй ажилд оруулах, олсон ашиг орлогоо хуваахаар амлах, өр зээлийг нь төлөх зэрэг арга замуудыг ихээхэн ашигладаг болохыг судалгааны дүн харуулж байна.

## 2.6 АВЛИГЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ МЭДЛЭГ ТОГТООХ СУДАЛГАА<sup>6</sup>

Азийн сан, Сант Марал сантай хамтран “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох” судалгааг зохион байгуулан явуулдаг юм. Тус судалгаанд дурдснаар өнгөрсөн долоон жилийн хугацаанд Монгол Улс дахь авлигын түвшний талаарх хандлагад ихээхэн эерэг хандлага бий болсон байна. 2012 оны 11 сард судалгаанд оролцсон хүмүүсийн 38.9 хувь “сүүлийн 3 жилд авлига нэмэгдсэн” гэж үзэж байсан бол 2013 оны 9 дүгээр сард энэ үзүүлэлт улам буурч 18.2 хувьд хүрсэн байна.


Энэхүү эерэг өөрчлөлт судалгаанд оролцогчдоос “авлига ирээдүйд нэмэгдэх үү” гэж асуухад мөн ажиглагдсан байна. 2012 оны 11 дүгээр сард судалгаанд оролцогчдын 12.5 хувь нь “ирэх гурван жилд авлига нэмэгдэнэ” гэж мэдэгдсэн байна. Харин 2013 оны 9 дүгээр сард ийнхүү мэдэгдэж байсан судалгаанд оролцогч 8.5 хувь хүртэл буурав. Ерөнхийдөө 2013 оны судалгаанд оролцогчид 2006 оныхтой харьцуулбал сэтгэл өөдрөг байна. Үүнтэй адилаар 2006 онд судалгаанд оролцогчдын 38.9 хувь “ирэх гурван жил авлига илүү их газар авна” гэж байсан бөгөөд 25.8 хувь нь “байдал сайжирна” гэсэн байна. Харин 2013 онд судалгаанд оролцогчдын зөвхөн 20.3 хувь “авлига нэмэгдэнэ” гэж мэдэгдсэн бөгөөд тэдний олонх болох 52.5 хувь нь “авлига буурна” гэдэгт итгэж байгаагаа илэрхийлсэн байна.

**Зураг 18. Сүүлийн гурван жилийн хугацаанд Монгол Улсад авлигын түвшин хэр их өөрчлөгдсөн бэ?**



<sup>6</sup> Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа, Азийн сан, 2013 оны 12 дугаар сар

**Зураг 19. Ирэх гурван жилийн хугацаанд Монгол Улсад авлигын түвшин хэр их өөрчлөгдөнө гэж бодож байна вэ?**



**Зураг 20. Авлигын эсрэг авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ**



**2.7 БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ<sup>7</sup>:**

Энэхүү судалгаа авлига бизнесийн орчинд хэрхэн нөлөөлж байгаа талаар бизнес эрхлэгчдийн санал бодол, туршлагыг олж мэдэх зорилгоор 2012 оны 12 дугаар сараас эхлэн Азийн сан, Сант Марал сантай хамтран зохион байгуулж буй судалгаа юм.


<sup>7</sup> Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгааны тайлан, Улаанбаатар 2013, Азийн сан,



Үр ашиггүй бэрхшээлийг (тухайлбал, зөвшөөрлийн хугацаа сунгах, тусгай зөвшөөрөлтэй холбоотой албан ёсны хариу авахыг хүлээх г.м.) даван туулахад компаниудын зарцуулсан цаг хугацаанд эерэг өөрчлөлттэй байсан өмнөх судалгааны чиг хандлага цаашид байхгүй болсон. 2013 оны 5 дугаар сард хийсэн судалгаагаар үүнд цаг хугацаа зарцуулдаггүй гэж мэдэгдсэн компанийн тоо 10.3 хувиар өссөн юм. Гэтэл энэ удаад ийм мэдэгдэл хийж байгаа компанийн тоо 15.8 хувь болж буурав (19.4 хувиас). Энэхүү үзүүлэлтээс болж үр ашиггүй бэрхшээлийг шийдвэрлэхээр цаг хугацаа зарцуулдаг компанийн тоо өсөхөд хүрэв. Үр ашиггүй бэрхшээлийг шийдвэрлэхээр ажлын цагийнхаа 25 хүртэл хувийг зарцуулдаг компанийн тоо 2013 оны 5 дугаар сард 19.4 хувь байснаа 10 дугаар сард 31.2 хувь болжээ.


Хэдийгээр ойрын жилүүдэд Монгол Улс дахь авлигын түвшинд эерэг өөрчлөлт гарсан ерөнхий үзүүлэлттэй байгаа боловч судалгаанд оролцогчдын 84 хувь нь төрийн албанд “тодорхой хэмжээний” болон “их” авлига байна гэж үзэж байна. Зөвхөн 11.2 хувь нь “бага хэмжээний” буюу “авлига байхгүй” гэж хариулжээ.

**Зураг 21. Төрийн байгууллагад авлига байна уу?**




Компаниудын 50 хувь нь төрийн байгууллага дахь авлига бизнест шууд нөлөөлж байна гэж мэдэгджээ. Энэ хувь 2013 оны 5 дугаар сарын үзүүлэлтээс 7 хувиар дээгүүр байв. Гэхдээ үүний үр нөлөө аажмаар буурч байгаа нь харагдаж байна. Авлига “ихээр” нөлөөлж байна гэж мэдэгдсэн хүний тоо 2012 оны 12 дугаар сард 35.2 хувь байсан нь 2013 оны 10 дугаар сард 21.8 хувь болж буурчээ.

**Зураг 22. Төрийн байгууллагын авлига бизнест шууд нөлөөлж байна уу?**



Төрийн байгууллагуудын дотор “төрийн үйлчилгээ” авлигад хамгийн өртөмтгий салбар гэдгээ тодорхой харуулав. 2013 оны 5 дугаар сард судалгаанд оролцогчдын 54.8 хувь үүнийг авлигад хамгийн өртөмтгий салбар гэж үзэж байсан бол 10 дугаар сард энэ нь нийт оролцогчийн 67.6 хувь болж хамгийн дээд байранд оров. Барилгын салбар мөн дээрх үзүүлэлтээр дээшилж 2013 оны 5 дугаар сард 47.3 хувиас 10 дугаар сард 58.2 хувь болсноор жагсаалтын 3 дугаарт оров.

**Зураг 23. Авлигад хамгийн их өртөмтгий салбарууд**



Бизнест саад бэрхшээл учруулдаг гэж тооцогддог бараг бүх байгууллага 2012 оны 12 дугаар сараас хойш өөрийн үйл ажиллагааг сайжруулсан байна. Татварын газрын талаарх сөрөг ойлголт 12 дугаар сард 35.4 хувь байсан бол 10 дугаар сард 26.7 хувь болжээ. Үүнтэй адилаар мөн хугацаанд Мэргэжлийн хяналтын байгууллага (28 хувиас 19.1 хувь болсон), цагдаа (8.1 хувиас 3.3 хувь болсон) болон орон нутгийн байгууллагын (9.9 хувиас 7.3 хувь болсон) талаарх сөрөг үнэлэмж буурсан байна.

**Хүснэгт 10. Бизнест бэрхшээл учруулж байгаа байгууллагууд**

	2012 12 сар	2013 5 сар	2013 10 сар
Мэргэжлийн хяналт	28.0%	23.6%	19.1%
Газрын алба	6.2%	5.8%	5.8%
Цагдаа	8.1%	5.2%	3.3%
Татварын алба	35.4%	29.1%	26.7%
Гааль	15.2%	13.3%	13.6%
Хот тохижилтын газар	1.2%	1.2%	1.2%
Ариун цэврийн алба	2.5%	2.7%	0.6%
Орон нутгийн захиргаа	9.9%	10.6%	7.3%
Бусад	3.7%	5.8%	4.5%
Мэдэхгүй	13.7%	20.0%	16.1%

## ГУРАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

---

Авлигатай тэмцэх газар нь 2013 онд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гүйцэтгэх ажлын тухай, Төрийн нууцын тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай зэрэг хууль тогтоомжийн хүрээнд хуулиар хүлээсэн бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлж ажиллалаа. Олон улсын “Транспарэнси Интернэшнл” байгууллагын Авлигын индексээр Монгол Улс 11 байраар ахиж, 83 дугаар байрт орсон, мөн түүнчлэн иргэд, олон нийт, төрийн албан хаагч, бизнес эрхлэгчдийн төлөөлөл болох хараат бус, хөндлөнгийн шинжээчдийн төсөөллийг үндэслэн гаргадаг Авлигын индексийн үнэлгээ 2011 оныхоос 0.02 пунктээр нэмэгдэж 0.65 болсон зэрэг эерэг үзүүлэлтээс харахад тус газар хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэн байна гэж дүгнэх боломжтой байна.

Авлигатай тэмцэх газрыг бэхжүүлэх, ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, төсөв, санхүүгийн нөөц бүрдүүлэх чиглэлээр төр, засгаас онцгой анхаарч байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй юм.

Улсын Их Хурал болон шинэчлэлийн Засгийн газраас сайн засаглалыг дэмжиж, авлигыг бууруулах томоохон зорилтууд тавьж байгаа энэ үед Авлигын эсрэг парламентчдын дэлхийн байгууллага (GOPAC)-ын Монгол дахь салбар бүлэг /MONPAC/ УИХ-д суудалтай бүх нам, эвслийн төлөөлөл сайн дураар нэгдэн авлигын эсрэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тэдгээрийг НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид нийцүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулахад зохих дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа нь дээд түвшний улс төрийн хүсэл зоригийн томоохон илэрхийлэл болж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар боловсруулсан Шүүхийн шинэтгэлийн багц хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Цагдаагийн албаны тухай, Тахарын албаны тухай зэрэг хуулийг батлан мөрдөж эхэлсэн нь НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн үзэл баримтлал, олон улсын шинжээчдийн өгсөн зөвлөмжид үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн чухал арга хэмжээний нэг боллоо гэж үзэж байна.

Улсын Их Хурлаас Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулиудыг баталсан нь хуулиудын уялдаа холбоог хангах, Авлигын эсрэг болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн зохицуулалтыг практик дээр нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, байгууллага, аж ахуйн нэгж, иргэд хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх, авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үр дүнтэй, хэвийн явуулах нөхцөл боломжийг бүрдүүлсэн болно.

Дээр дурдсан томоохон арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ НҮБ-ын Авлигын эсрэг конвенци болон олон улсын шинжээчдийн зөвлөмжид үндэслэн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг шинэчлэн баталж, зарим нэмэлт, өөрчлөлт оруулсан болон өөрсдөө илрүүлсэн тохиолдолд Авлигатай тэмцэх газар мөнгө угаах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалт хийсэн зэрэг нь Монгол Улс Мөнгө угаах гэмт хэргийн талаар “FATF” байгууллагын хар жагсаалтаас гарч саарал жагсаалтад шилжихэд чухал түлхэц болсон гэж үзэж байна.

Төр засгаас авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ буюу эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар хийсэн шинэчлэл,

авлига, албан тушаалын хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт нь Монгол Улс Транспарэнси Интернэшнл байгууллагын Авлигын төсөөллийн индексийн үр дүнгээр 38 оноогоор 83 дугаар байрт дэвшин олон улсын түвшинд Монгол Улсын нэр хүнд өсөхөд нөлөөлсөн гэж дүгнэж байна.

Улсын Их Хурлаас 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр баталсан Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу улсын хэмжээнд хэрэгжүүлэх Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах, үндэсний хөтөлбөрийг төрийн байгууллага, албан тушаалтан биелүүлэх, биелэлтийг холбогдох байгууллагад тайлагнах эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар энэхүү хөтөлбөрийн төслийг боловсруулахад тус газар дэмжлэг үзүүлэн, хөтөлбөрийн төслийг улс орон даяар хэлэлцүүлэх ажлыг хамтран зохион байгуулсан болно.

Авлигатай тэмцэх бодлогыг өнөөгийн нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тодорхойлж, төсвийн байгууллагын санхүүгийн гүйлгээг олон нийтэд ил болгох, улс төрийн намын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай дэд бүтцийг сайжруулах, хөгжүүлэх, цахим худалдан авах ажиллагааны тогтолцоог нэвтрүүлэх, зорилтот бүлгүүдэд чиглэсэн үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшил, олон нийтийн оролцоог хангах замаар үндэсний хэмжээнд зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг тусгай аргачлалын дагуу үнэлж, тэдгээрийг үр дүнг олон нийтэд мэдээлснээр байгууллагуудын авлигатай тэмцэх үйл ажиллагааны түвшин тодорхой болсон бөгөөд тэдгээр нь авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаа бодитой төлөвлөн хэрэгжүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх чиглэлээр идэвх санаачилгыг өрнүүлэх нөхцөл болсон гэж дүгнэж байна.

Орон нутагт авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах, тэднийг арга зүйн зөвлөгөөгөөр хангах, төрийн бус байгууллагуудыг төрийн байгууллагын үйл ажиллагаанд мониторинг хийлгэх асуудалд түлхүү анхаарч, соён гэгээрүүлэх ажлыг хүүхэд, залуучуудад чиглүүлснээр авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх ажилд ахиц гарсан болно.

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг орон нутагт ажиллах явцдаа илрүүлсэн нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд оршиж буй нийтлэг зөрчил, дутагдал нь байгууллага, албан тушаалтны хариуцлагыг дээшлүүлэх, хяналтын оновчтой тогтолцоо бүрдүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байгааг харуулж байна. Тухайлбал, төсвийн хөрөнгөөр баяр наадам зохион байгуулахдаа төсвийг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэх, шагнал урамшууллыг хавтгайруулан олгох, баяр наадам тэмдэглэх зорилгоор хандив цуглуулах ажлыг зохион байгуулах, хандив өгсөн этгээдийн талд шийдвэр гаргах, жижиг дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүд холбогдох журмын хүрээнд хэрэгждэггүй, зарим сумдад төсвийн хөрөнгийг “Орон нутгийн нөөц санг төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлийг тооцох нийтлэг журам”-д заагдсан зориулалтаас гадуур зарцуулах, Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг батлахдаа Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан хориглох зүйлсийг баримтладаггүй, сум бие даан хэрэгжүүлэх чиг үүргийг хэтрүүлэн баталдаг зэрэг зөрчлүүд нийтлэг байна.

2014 онд урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бодлогын түвшинд уялдуулан хэрэгжүүлэх, авлигад өртөх эрсдэл өндөр салбаруудад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг бодлогын хүрээнд илүү цэгцтэй явуулахад гол анхаарлаа хандуулан ажиллах болно.

Улсын хэмжээнд нийт 47000 гаруй мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргадаг бөгөөд Цахим гарын үсгийн тухай хууль тогтоомж хэрэгжиж эхэлмэгц ХАСХОМ-ийг цахим хэлбэрээр бүрэн бүртгэх нөхцөл боломж бүрдэнэ. Цахим програм хангамжийг ашиглаж эхэлснээр цаашид кибер халдлагад өртөх, мэдүүлэг гаргагчдын хувийн мэдээлэл задрахаас сэргийлэх, хамгаалалтын арга хэмжээг урьдчилан авах, одоо байгаа техник, тоног төхөөрөмжүүдийг сайжруулах шаардлага гарч байна.

Жилд дунджаар дээр дурдсан мэдүүлэг гаргагчдын 500-550 орчим албан тушаалтны мэдүүлгийг нарийвчлан хянан шалгаж байгаа нь нийт мэдүүлэг гаргагчдын 1,1 хувийг эзэлж байна. Нийт шалгасан ХАСХОМ-ийн дүнд орон нутагт ажиллаж байгаа албан тушаалтны мэдүүлгийг шалгасан байдлыг үзэхэд 2007-2008 онд мэдүүлгийн хяналт шалгалт орон нутагт бага хувьтай буюу нийт шалгасан мэдүүлгийн 1 хүртэл хувийг эзэлж байсан бол 2010 онд 13,7 хувийг, 2011 онд 37,1 хувийг, 2012 онд 25,1 хувийг, 2013 оны 10 сарын 10-ны байдлаар 26,5 хувийг тус тус эзэлж байна. Цаашид орон нутагт хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2013 онд улсын хэмжээнд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 10400 гаруй этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан бөгөөд хуульд заасан хугацаанд буюу ажлын 10 хоногт багтаан хянахад хугацаа алдах, хяналт шалгалтыг бүрэн, дүүрэн хангалттай хянан үзэх, шаардлагатай баримтуудыг гаргуулан авах боломжгүй нөхцөл байдал үүсдэг. Иймд “нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн” гэдэг ойлголтод шилжин томилогдох, албан тушаал нь өөрчлөгдөх, сэлгэн ажиллуулах, шүүхийн шийдвэрийн дагуу ажилд эргүүлэн томилогдох, түр хугацаагаар томилогдох, хүүхэд асрах чөлөөний хугацаа дууссаны дараа өмнө эрхэлж байсан ажилдаа буцаж томилогдох, ажиллаж буй бүтцийн нэгж дотроо өөр ажлын байранд томилогдох зэрэг тохиолдлыг бүгдийг хамруулж байгааг эргэж нягтлах, хуулийн үйлчлэлд хамрагдах хүрээг багасгах зэргээр хууль эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох шаардлага гарч байна.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүйгээр тухайн албан тушаалд томилж байгаа эрх бүхий албан тушаалтан буюу удирдах албан тушаалтанд хариуцлага тооцуулах асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай байна. Мөн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд нь Төрийн албаны тухай хуульд заасан болзол шалгуурыг хэрхэн хангаж байгаа, сонгон шалгаруулалтад орж тэнцсэн, нөөцөд авагдсан эсэх, тухайн ажлын байранд тавигдах, шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд Төрийн албаны зөвлөл болон тухайн байгууллагын Төрийн албаны салбарт зөвлөлтэй хамтран ажиллагаагаа идэвхжүүлэх хэрэгцээ шаардлага харагдаж байгаа болно.

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбар гаргах үүргээ биелүүлэхгүй байх, хамаарал бүхий этгээдтэйгээ холбоотой захиргааны акт гаргах, гэрээ байгуулах, аж ахуйн үйл ажиллагаа давхар эрхлэх, бэлэг хандив, авахтай холбоотой хязгаарлалтыг давах зэргээр хууль тогтоомжийг зөрчих явдал түгээмэл байна. Энэ нь сумдын хүн ам цөөн, нэг гэр бүл, төрөл садны хүмүүс нэг нутаг дэвсгэрт төвлөрч амьдардаг, улс төрийн сонгуулийн үр дүнгээр сонгогддог албан тушаалтнууд нь тухайн орон нутаг дахь өөрийн хамаарал бүхий этгээдүүдэд давуу байдал олгох, эрх ашгийг нь хөндсөн шийдвэр гаргах хандлагатай, мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнууд албан тушаалдаа

тогтвортой ажилладаггүй, хууль тогтоомжийн талаар ойлголт муу байгаатай холбоотой байна.

Авлигатай тэмцэх газарт ирсэн гэмт хэргийн шинжгүй өргөдөл, гомдол, мэдээллийн 48,5 хувийг орон нутгийн байгууллага, албан тушаалтантай холбоотой гомдол, мэдээлэл эзэлсэн нь орон нутагт сонирхлын зөрчлийн хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна. Ялангуяа, хамаарал бүхий этгээдүүд буюу төрсөн ах, дүү, гэр бүлийн гишүүд нэг дор ажиллаж байгаа, хамаарал бүхий этгээд нь тендерт оролцож төсвийн хөрөнгийг хууль бусаар зарцуулсан, өөртөө болон бусдад давуу байдал олгосон, сонирхлын зөрчилтэй томилгоо хийдэг гэх өргөдөл, гомдол зонхилж байна. Иймд орон нутаг дахь удирдлагуудад авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн мэдээллийн систем”-ийн хөгжүүлэлт, шинэчлэлтийг байнга хийж, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны сургалтыг орон нутагт бүсчилсэн байдлаар жил бүр тогтмол зохион байгуулан чадавхжуулах шаардлага гарч байна.

Авлигатай тэмцэх газарт ирсэн гомдол, мэдээлэл, үйлдэгдсэн гэмт хэргийн гаралтаас дүгнэхэд манай улсад үйлдэгдэж байгаа авлига, албан тушаалын гэмт хэргийн гаралт агентлаг, төрийн захиргааны байгууллагын орон нутаг дахь салбар нэгж, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад ажиллаж байгаа ажилтнуудын хувьд өсөх хандлагатай байгааг анхаарч гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоох, арилгахад чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ авлига, албан тушаалын гэмт хэргийг хянаж шийдвэрлэдэг прокурор, шүүгчдийг мэргэшүүлэх, энэ төрлийн гэмт хэргүүдийг хуульчилсан хууль тогтоомж, бусад эрх зүйн актын талаар нэг мөр ойлголттой болох үүднээс хамтарсан сургалтуудыг явуулах шаардлагатай байна.

## **АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**

## **Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1. Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааны үнэлгээ, хувиар .....	4
Хүснэгт 2. Албан тушаалтнуудын мэдүүлгийн бүрдүүлэлт, оноор .....	11
Хүснэгт 3. Мэдүүлгийн бүрдүүлэлт, бүрдүүлэлтийн дараахь хяналт шалгалтын үр дүнгээр хариуцлага тооцуулсан байдал, 2013 онд .....	12
Хүснэгт 4. Хүлээн авсан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт .....	16
Хүснэгт 5. Авлигын төсөөллийн индексийн утга болон үнэлгээнд хамрагдсан улс орнууд дунд эзлэх байр .....	22
Хүснэгт 6. Дэлхий нийтийн авлигын хэмжүүр судалгааны дүн .....	23
Хүснэгт 7. Авлигын цар хүрээний үзүүлэлт, дэд үзүүлэлтээр .....	25
Хүснэгт 8. Авлигын шалтгаан нөхцөл, шинжээчдийн болон олон нийтийн төсөөллийн судалгаа /хамгийн их нэрлэсэн шалтгаан нөхцөлөөр/ .....	26
Хүснэгт 9. Төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ .....	29
Хүснэгт 10. Бизнес бэрхшээл учруулж байгаа байгууллагууд .....	34

## **Зургийн жагсаалт**

Зураг 1. ХАСХОМ-ийн хяналт шалгалт .....	12
Зураг 2. ХАСХОМ-ийн хяналт шалгалтын үр дүн .....	13
Зураг 3. Хүлээн авсан гомдол, мэдээлэл, субъектээр .....	13
Зураг 4. Өргөдөл, гомдлын агуулга .....	14
Зураг 5. Хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдол .....	14
Зураг 6. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн хяналт .....	15
Зураг 7. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн хүрээнд хариуцлага тооцуулсан тоо, 2013 онд .....	15
Зураг 8. Иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийн тоо, гомдол, мэдээлэлд холбогдох байгууллага, салбараар ангилбал .....	16
Зураг 9. Мөрдөн байцаалт явуулсан нийт хэрэг, үйлдлийн тоо, Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр .....	18
Зураг 10. Мөрдөн шалгасан эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийн тоо, 2013 он .....	18
Зураг 11. Эрүүгийн хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдсан хүний тоо, албан тушаалын байдлаар, 2013 онд .....	19
Зураг 12. Монгол Улсын Авлигын индекс, оноор .....	24
Зураг 13. Монгол Улсын Авлигын индексийн дэд үзүүлэлт, оноор .....	24
Зураг 14. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, /2010-2013 онд, дүнд эзлэх хувиар/ .....	25
Зураг 15. Авлигын индекс болон авлигад өртөх эрсдэл, /аймаг, нийслэлээр, 2013 онд/ .....	27
Зураг 16. Авлигын индекс болон авлигад өртөх эрсдэл, /Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудлын хүрээгээр, 2013 онд/ .....	28
Зураг 17. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн үнэлгээ .....	30
Зураг 18. Сүүлийн гурван жилийн хугацаанд Монгол Улсад авлигын түвшин хэр их өөрчлөгдсөн бэ? .....	31
Зураг 19. Ирэх гурван жилийн хугацаанд Монгол Улсад авлигын түвшин хэр их өөрчлөгдөнө гэж бодож байна вэ? .....	32
Зураг 20. Авлигын эсрэг авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ .....	32
Зураг 21. Төрийн байгууллагад авлига байна уу? .....	33
Зураг 22. Төрийн байгууллагын авлига бизнест шууд нөлөөлж байна уу? .....	33
Зураг 23. Авлигад хамгийн их өртөмтгий салбарууд .....	34